МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

mminfo.mn Шударга, Шуурхай, Олигой мэдээлэл

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,086,904... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.06.03. Баасан. №113 (4483) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

**УЛС ТӨР**

МОНГОЛ ЗАЛУУС ЯПОНД ДАДЛАГАЖИХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО

II нүүрт

**ДЭЛХИЙ**

ХЯТАД, БНАСАУ-ЫН ХАРИЛЦАА САЙЖИРЧ БАЙНА

VII нүүрт

**УРАН БҮТЭЭЛЧ**



# Д.АЛТАНХУЯГ: ЗАЛУУ ХҮНИЙ ДҮРЭЛЗСЭН ЭРЧ ХҮЧЭЭР БАЛЕТЫН УРЛАГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ

Дэлгэрэнгүй ярилцлагыг V нүүрнээс

Дугаарын 60 мөр

## Зусланд амраахын зэрэгцээ эрүүл мэндийг нь нэг шалгуулчих

Ж.ОТГОНМЯГМАР

Сурагчдын зуны амралт эхэлж, зун цагийг зугаатай өнгөрүүлэх мөч ойртсоор байна. Хүүхдийн зуслангууд ч хүүхэд багачуудаа хүлээн авахаар бэлтгэлээ аль хэдийнэ базааж, зарим нь ч эрхийн бичгээ худалдаад эхэлжээ. Одоогоор нийслэлд 24 зуслан үйл ажиллагаа явуулахаар мэдүүлгээ өгөөд байгаа бөгөөд төлбөрийн дундаж үнэ хоногийн 23-25 мянган төгрөг байх гэнэ. Түүнчлэн зуслангийн эхний ээлж энэ сарын 08-нд эхлэх тов ч гарчээ. Бэлтгэл ажлын хүрээнд "Хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөр" бүлгийн удирдагч багш бэлтгэх сургалтыг "Мөрөөдөл" хүүхдийн зусланд зохион байгуулж, нийт 90 оюутан залуус хамрагдсан юм байна. Мөн хүүхдийн зуслангийн эмч, тогооч нарын "Хүүхдийн зуслангийн эрүүл ахуй" сургалтыг ч явуулжээ.

Үргэлжлэл нь III нүүрт

# ХЭН ЮУ ХЭЛЭВ

Б.ТОГТОХ

### Д.Оюунхорол: I одонтой эхэд сая, II одонтой эхэд 500 мянган төгрөг өгөх хууль санаачилсан

-Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг Монгол Улс өнөө жил 64 дэх жилдээ өргөн дэлгэр тэмдэглэлээ. Тэгвэл энэ баярт өдөр олон ээжүүд "арын хаалгагүй цорын ганц шагнал" хэмээн нэрлэгддэг "Алдарт эх-"ийн I, II одонгоор шагнуулсан юм. Тэгвэл олон хүүхэдтэй эхийг урамшуулах талаар чамгүй олон ажил санаачилж, эхчүүдийг урамшуулах тогтолцоог бий болгох талаар идэвхтэй ажиллаж яваа УИХ-ын гишүүн Д.Оюунхоролын хэвлэлд өгсөн ярилцлага олны анхаарлыг татлаа. Тэрбээр, "2010 оны зургадугаар сард энэ хуульд нэмэлт өөрчлөлт оруулж зургаан хүүхэдтэй эхэд I одон, дөрвөн хүүхэдтэй эхэд II одон өгдөг байхаар батлуулж чадсан. Энэ нь нэгдүгээрт Монгол Улсын хүн ам зүйн бодлогыг дэмжсэн. Урамшууллыг бий болгож өгснөөр өнөөдөр одонтой эхчүүдийн тоо өсч хүүхдийн тоо нэмэгдэж байна. Ингэснээр жилд дунджаар 1500 орчим ээж I одон, 8000 орчим ээж II одон авч байна. Хуулийн нэмэлт өөрчлөлт манай хүн амзүйн бодлогод гарцаагүй нөлөөлсөн. Гэхдээ бид ингээд л боллоо гэж хэлэхгүй.

Үргэлжлэл нь III нүүрт

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**




ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

60 ANNIVERSARY



# МИАТ ХК түрээсийн Боинг 767-300 агаарын хөлгөө хүлээн авлаа




Үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ТӨХК өчигдөр АНУ-ын Боинг компанид үйлдвэрлэсэн, EI-FGN бүртгэлийн дугаартай B767-300 маягийн агаарын хөлгийг үйл ажиллагаандаа ашиглахаар хүлээн авлаа. Тус агаарын хөлгийг хүлээн авах ёслолын ажиллагаанд ЗТЯ-ны Агаарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Н.Мөнхнасан, ИНЕГ-ын дэд дарга Д.Батчулуун, "Чингис Хаан" ОУНБ-ын захирал Б.Бадрал, МИАТ ТӨХК-ийн Нислэг, техникийн үйл ажиллагааны захирал Н.Ганболд, Коммерийн захирал Т.Батчулуун, Захиргаа, эрх зүйн хэлтсийн дарга Б.Баасанцогт нар оролцов. B767-300 агаарын хөлгийг Нислэгийн хэлтсийн дарга, багш нисгэгч Ж.Доржнамжил ахлагчтай баг Францын Марсел хотоос жолоодон амжилттай газардуулл аа. Англи улсын Pembroke Aircraft Leasing компаниас түрээслэн авч байгаа тус агаарын хөлөг нь чиг шулууны 10-12,500 м өндөрт 850 км цагийн хурдтайгаар 11000 км зайд зогсолтгүй нисэх чадвартай. Онгоцны урт 54.9 м, далавчны өргөн нь 47.6 м, их биеийн өндөр 5.41 м, их биеийн өргөн 5.03 м юм байна.

МИАТ ТӨХК үйл ажиллагаандаа ашиглаж байсан JU-1011 бүртгэлийн дугаартай B767-300 агаарын хөлгийн хөдөлгүүрийн ашиглалтын цикль дууссан тул дээрх онгоцыг ийнхүү түрээсийн гэрээгээр ашиглахаар болжээ.

**EI-FGN бүртгэлийн дугаартай Б767-300 маягийн агаарын хөлгийн техникийн үзүүлэлт**

| | |
|---|---|
| Онгоцны бүртгэлийн дугаар | EI-FGN |
| Онгоцны марк | 767-300 |
| Урт (м) | 54,9 |
| Онгоцны далавчны дэлгэц (м) | 47,6м |
| Өндөр (м) | 5,41м |
| Нисэх жин (кг) | 186,808 |
| Их биеийн өргөн | 5,03м |




**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1982.00 | 1998.00 | ФУНТ | 2821.00 | 2907.00 |
| ЕВРО | 2200.00 | 2255.00 | РУБЛЬ | 27.90 | 31.60 |
| ИЕН | 18.00 | 18.45 | ЮАНЬ | 299.50 | 303.70 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1987.00 | 1998.00 | ФУНТ | 2836.00 | 2905.00 |
| ЕВРО | 2202.00 | 2259.00 | РУБЛЬ | 28.79 | 31.18 |
| ИЕН | 18.01 | 18.52 | ЮАНЬ | 300.30 | 303.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Ч.Даваабаяр, Б.Сүрэнжав нар нэрээ татжээ

АН-ын Гүйцэтгэх зөвлөлийн хуралдаанаар АН Өвөрхангай, Увс аймгийн тойргийг хэлэлцэж, хоёр нэр дэвшигчийн нэрийг эгүүлэн татах шийдвэрт хүрчээ. Тодруулбал, Өвөрхангай аймгийн Засаг дарга Б.Тогтохсүрэнтэй тус аймгийн 20 дугаар тойрогт өрсөлдөх байсан Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны Ерөнхийлөгч Ч.Даваабаярыг эгүүлэн татахаар болсон байна. Мөн Увс аймагт нэр дэвшээд байсан УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатартай 33 дугаар тойрогт өрсөлдөх нэр дэвшигч Баянмөнх аваргын охин Б.Сүрэнжавыг өөрчилж тус тойрогт “Оюуны ундраа” группийн захирал С.Отгонбаярыг нэр дэвшүүлэх шийдвэрт хүрчээ. Мөн Ч.Даваабаярын оронд “Дэлгэрэх хүнс” компанийн захирал Д.Жаргал нэр дэвших аж. Хуульд нэгэнт баталсан нэр дэвшигчийг эгүүлэн татах хуульзүйн заалт тодорхой бус ч хуулийн гаргалгаа байгаа гэдгийг зарим хуульчид онцолж байгаа юм. Сонгуулийн тухай хуульд зааснаар дээрх тохиолдолд нэр дэвшигчийг солих зохицуулалт тусаагүй байгаа. Харин Сонгуулийн тухай хуулийн 130.1 Нам, эвслээс нэр дэвшигч нас барсан, эсхүл шүүхээр ял шийтгүүлсэн тохиолдолд тухайн нам эвсэл нь өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлэх шийдвэрээ санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө ирүүлж, энэ хуульд заасан журмын дагуу бүртгүүлж болно хэмээн заажээ.

АЙЛЧЛАЛ

# МОНГОЛ ЗАЛУУС ЯПОНД ДАДЛАГАЖИХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО

Ж.МЯГМАР



Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан Япон улсад албан ёсны айлчлал хийж буй УИХ-ын дарга З.Энхболдын багт ажиллаж байгаа юм. Тэрбээр өмнө нь тус улсад хийсэн ажлын айлчлалынхаа үеэр Монгол Улсын ирээдүйн хөгжлийн хөтөч байх өндөр мэргэжилтэй, ур чадвартай ажилтнуудыг хамтран бэлтгэх тал дээр Япон улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн сайд Я.Шиозакитай тодорхой яриа хэлцлийг өрнүүлжээ. Тэрхүү яриа хэлэлцээ бодит ажил болж монгол залуусыг Японд мэргэжил дээшлүүлэх, дадлагажуулах боломжийг бүрдүүлсэн Засгийн газар хоорондын Санамж бичгийг өчигдөр албан ёсоор байгуулсан байна.

Токио хотноо байгуулсан “Хөдөлмөрийн салбар дахь хамтын ажиллагааны санамж бичиг”-т Монгол Улсын Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан, Япон улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн сайд Я.Шиозаки нар гарын үсэг зурсан юм. Японы Ерөнхий сайдын өргөөнд болсон гарын үсэг зурах ёслолд УИХ-ын дарга З.Энхболд, Японы Ерөнхий сайд Шинзо Абэ болон УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга, Япон-Монголын парламентын бүлгийн дэд дарга Д.Ганбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарын албаны хүмүүс оролцлоо. Энэ үеэр Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан “Хөдөлмөрийн салбар дахь хамтын ажиллагааны санамж бичиг” нь хоёр улсын хоорондын шинэ технологи, хүн солилцоо болон цаашдын хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна гэдгийг онцлоод “Энэ нь манай хоёр орны Засгийн газар хоорондын анхны Санамж бичиг гэдгээрээ онцлогтой. Ингэснээр монгол залуус олноороо Япон улсад өндөр технологи эзэмшиж, япон соёл, ноу-хауг суралцах боломж бүрдэж байгаа юм. Манай Хөдөлмөрийн яамны хувьд Японд мэргэжил дээшлүүлж, дадлагажих хүсэлтэй залуусыг эхний ээлжинд хэлний сургалтад хамруулж, сургалтыг өөрийн харьяа мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагууд дээрээ явуулахаар бэлтгэл ажлыг хэдийнэ эхлүүлсэн байгаа. Тиймээс зохих журмын дагуу бүртгүүлж, хэлний мэдлэг эзэмшсэн залуусыг Япон улсад дадлагажигчаар илгээх ажил нэн даруй эхлэх боломжтой. Дадлагажигч ажилчдыг бид ихэвчлэн бүтээн байгуулалт, үйлдвэр, дэд бүтэц, эрүүл мэндийн салбарт ажиллуулахаар төлөвлөж байна” хэмээжээ. Монголоос дадлагажигч ажилтан авч мэргэшүүлэх замаар шаардлагатайболовсонхүчнийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх тухай 2013 онд байгуулсан “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр”-т төдийгүй ойрын үед хүчин төгөлдөр болох гэж буй Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр /EPA/-т ч тодорхой тусгасан байдаг. Энэ удаа байгуулсан Засгийн газар хоорондын санамж бичгээр ур чадварын дадлагажигч илгээх ажил улам бүр баталгаажиж, цар хүрээ нь нэмэгдэж буйг албаны хүмүүс онцоллоо.

### Хагас коксжсон шахмал түлшний үйлдвэрлэлийн төсөл хэрэгжүүлнэ

УИХ-ын дарга З.Энхболд болон Японы Ерөнхий сайд Ш.Абэ нар Монгол Улсын Уул уурхайн яам, Япон Улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам хоорондын “Цэвэр нүүрсний технологийн солилцоог дэмжих хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг үзэглэх ёслолд оролцов. Энэхүү санамж бичигт гарын үсэг зурснаар Монгол Улсад үр ашигтай нүүрсний хэрэглээг дэмжих зорилгоор цэвэр нүүрсний технологийн солилцоог гүнзгийрүүлэх, хамтарсан судалгааг дэмжих аж. Түүнчлэн нүүрс хийжүүлэх технологи болон хагас коксжсон шахмал түлшний үйлдвэрлэлийн төсөл хэрэгжүүлэх зэргээр хоёр улс хамтран ажиллах боломж бүрдэх аж. Нүүрс бол Монгол Улсын чухал баялгийн нэг мөн. Өнөөдөр Монгол Улс 173 тэрбум тонн геологийн нөөцтэй. 34 сая тонн батлагдсан нөөцтэй бөгөөд цаашдаа ч энэ тоо нэмэгдэнэ. Нүүрс бол эрчим хүчний нөөцөөрөө цаашид 170 гаруй жил дэлхийд ашиглагдах боломжтой гэсэн судалгаа бий. Дэлхий нийтэд түүхий нүүрсний хэрэглээг багасгах хандлага байгаа ч цаашид нүүрсний технологийг дээшлүүлэн, боловсруулалтын төвшинийг сайжруулж ашиглахаас өөр гарцгүй. Манай улсын өмнө цаашид нүүрсийг үр ашигтай ашиглах шаардлага бий. Энэ чиглэлийн анхны алхам тавигдаж байна. Шинэ нүүрсний цэвэр технологи нь нүүрсийг хийжүүлэн, гарсан хийгээр нь эрчим хүч үйлдвэрлэхээрээ ялгаатай. Монгол Улс цаашид нүүрс, химийн үйлдвэрийг хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байгаа хэмээн Засгийн газрын гишүүн, Уул уурхайн сайд Р.Жигжид хэллээ.


МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс: 976-70113551**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**


МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Н.Энхбаяр: МАНАН шударга бус сонгууль явуулж байна



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.САРНАЙ

МАХН-ын дарга Н.Энхбаяр өчигдөр шуурхай хурал зарлалаа. Тус хэвлэлийн бага хуралд намын дарга Н.Энхбаяр, дэд дарга Э.Эрдэнэжамъян, өмгөөлөгч Н.Оюунбилэг нарын хүмүүс оролцсон юм. УИХ-ын ээлжит сонгууль энэ сарын 29-нд болно. Тэгвэл энэ удаагийн сонгуульд МАХН-ын дарга Н.Энхбаяр, болон дэд дарга Э.Эрдэнэжамъян нарын таван гишүүнийг оролцуулахгүй гэсэн шийдвэрийг СЕХ-ноос гаргажээ. Тиймээс Н.Энхбаяр энэхүү шийдвэртэй холбогдуулан хэвлэлийн хурал зарласан байна. Тэрбээр, “Сонгууль шударга явагдах ёстой. Харамсалтай нь өнөөдөр УИХ-ын өмнөх жилийн сонгуулиар луйвардаж байсан МАН, АН одоо болтол луйвардсан хэвээр. Өөрсөддөө ашигтай байдлаар дамжуулан шударга бус сонгуулийг явуулж байна. Би хэдхэн хоногийн өмнө өлсгөлөн зарлаж эсэргүүцлээ илэрхийлсэн. Намайг болон бусад нэр дэвшигчдийг сонгуульд оруулахгүй байх үйл ажиллагаа явуулж байна. Үүнд цагдаагийн байгууллага оролцсон. Цагдаагийн Ерөнхий газарт тухайн дүгнэлтээ засч өгнө үү гэсэн хүсэлт гаргасан. Мөн Дээд шүүхэд хандсан. Манай гишүүд Ардчилсан намыг дэмжиж үнэнчээр ажилласан. Биднийг Засгийн газрыг тогтвортой ажиллуулсны дүнд Ч.Сайханбилэг ийм хариу барьж байгаа юм байна. Төр засаг тогтвортой ажиллах ёстой гэж бодож ажилласан. Илт цөөнх байсан учраас амлалтаа хэрэгжүүлж чадаагүй, цаашид олонх болж амлалтаа биелүүлэхийн төлөө ажиллана” гэв. Энэ үеэр УИХ-ын гишүүн О.Баасанхүү “Хүний эрхийн комисс нь Нэгдсэн үндэстний байгууллагын харьяа байгууллага. Тус байгууллага Н.Энхбаяр даргад ялтай эсэх тодорхойлолт хамаагүй гэж дүгнэсэн. Гэтэл цагдаагийн байгууллага энэ тодорхойлолтыг гаргаж өгөхгүй байна. Цагдаагийн байгууллага бол ял шийтгэлийн талаар “Тийм, үгүй” гэх лавлагаа өгөх үүрэгтэй болохоос хууль тайлбарлах газар биш. Манай улсын сонгуулийг ажиглахаар ирсэн гадаадын ажиглагчид гайхаж байна” хэмээлээ. Н.Энхбаяр дарга болон дэд дарга Э.Эрдэнэжамъян нарын тухайд ялтай эсэх хугацаа дуусаагүй учраас сонгуульд нэр дэвшүүлэх боломжгүй гэж үзжээ. Харин бусад гишүүд бичиг баримтаа дутуу ирүүлсэн гэдгийг СЕХ-ноос мэдэгдсэн юм.

## АСЕМ-ын төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлууд бэлэн гэв

Ази, Европын дээд төвшний 11 дүгээр уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд АСЕМ-ын зочид төлөөлөгчдийг хүлээн авах хурлын байр, зочид буудлуудын ажлыг хариуцсан ажлын хэсгийнхэн мэдээлэл хийлээ. Дээд төвшний уулзалтын хүрээнд 40 зочид буудал түнш зочид буудлаар сонгогдсон байна. Тодруулбал, төвийн Шангри Ла, Блю Скай, Бэст Вестерн Туушин зэрэг долоон зочид буудалд 1000 орчим сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон хэвлэлийн албаныхан байрлах аж. Харин бусадтүншлэгч30зочидбуудлыг хурлын төлөөлөгчдөд зориулан ангилан бэлдэж байгаа юм байна. АСЕМ-ын зочид төлөөлөгчдийг хүлээн авах хурлын байр, зочид буудлуудын ажлыг хариуцсан нарийн бичгийн дарга Т.Тэгшжаргал “АСЕМ-ын долдугаар сарын 15-16-ны хооронд үргэлжлэх гол хурлыг Шангрилла зочид буудалд явуулна. Түүнээс гадна хурлын төлөөлөгчдийг байрлуулах зочид буудлуудын асуудлыг зохицуулсан. Орон орноор нь буюу нэг орны төлөөлөгчдийг нэг зочид буудалд тэр чигт нь байрлуулахгүй жигдхэн хуваарилахад анхаарч байгаа” гэлээ. Төлөөлөгчдийн онлайн бүртгэл эхэлсэн бөгөөд байрлах зочид буудалд захиалга хийгдэж эхэлсэн байна. Түүнчлэн зочид хуралд ойр байрлалтай буудлыг ихэвчлэн сонирхон захиалга өгч байгааг ажлын албаныхан хэллээ. Одоогоор “Шангри Ла” зочид буудалд 24 орны 280, “Бэст Вестерн Туушин” зочид буудалд 16 орны 190, “Блю Скай” зочид буудалд долоон орны 180 зочин, төлөөлөгч албан ёсны захиалга өгсөн байна. “АСЕМ Вилла” цогцолборын ерөнхий менежер Д.Алтанзул “Бид 53 виллад 53 улсынтөрийнтэргүүнийгхүлээж авна. Үндэсний уламжлалт өв соёл Монголын зочломтгой байдлыг харуулах ажлын бэлтгэл ажил явагдаж байна. Одоо тохижилттой холбоотой асуудал л үлдээд байгаа. ХХААЯ, Хөдөлмөрийн яамтай хамтарч 300 орчим боловсон хүчнийг энэ сарын 15 гэхэд “АСЕМ Вилла” цолцолборын зочид буудлын үйлчилгээ хариуцсан манай багийнхан MCS-д хүлээлгэж өгнө” гэлээ

## ИЗНН нэр дэвшигчдээ тодруулна

Сонгуулийн Ерөнхий хорооноос ИЗНН-ыг сонгуульд оролцуулахгүй гэх шийдвэрийг гаргасан ч тус намаас шүүхэд гомдол гаргасан. Тэгвэл Улсын дээд шүүхээс СЕХ-г хууль зөрчин шийдвэр гаргасан гэж үзэн ИЗНН-ыг 2016 оны сонгуульд оролцуулахаар бүртгэх нь зүйтэй гэсэн шийдвэрийг гаргасан. Энэхүү шийдвэрийн дагуу ИЗНН-ыг УИХ-ын сонгуульд оролцуулахаар Сонгуулийн ерөнхий хорооноос өнгөсөн тавдугаар сарын 31-нд бүртгэж авсан. Хэдийгээр Сонгуулийн тухай хуулийн дагуу УИХ-д нэр дэвшигчдийг бүртгэж дууссан ч шүүхийн шийдвэрийн дагуу ИЗНН-ын нэр дэвшигчдийг бүртгэн авах юм. Өөрөөр хэлбэл бүртгэж авснаас хойш тав хоногийн хугацаанд буюу энэ сарын 5-ны дотор нэр дэвшигчдээ мэдүүлэх, баримт материалыг нь бүрдүүлэх өгөх чиглэлийг ИЗНН-д Сонгуулийн ерөнхий хорооноос өгчээ.

## Нийслэл, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтрахаар боллоо

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг Улаанбаатар хотод тодорхойлох, Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд шаардагдах урт хугацааны бодлогын баримт бичиг болон хөгжлийн зорилтуудад хүрэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах чиглэлээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Хамтын ажиллагааны санамж бичигт нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч Биата Транкман нар гарын үсэг зурав. Энэ үеэр нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл “Юуны өмнө Улаанбаатар хотыг бүх талаар дэмжин ажиллаж, гүн туслалцаа үзүүлж байдаг НҮБ-д талархал илэрхийлье. НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн хийж байсан гэр хорооллын ядуурлыг бууруулах ажлын суурь дээр үндэслээд бид том алхам хийх гэж байна. Таны хэлсэнчлэн хөгжлөөс иргэдээ хоцроохгүй байх зарчим бол маш чухал. Хөгжлөөс иргэнээ хоцроохгүй байж чадсан тохиолдолд тогтвортой хөгжил бий болдог. Тийм учраас уг санамж бичгийг байгуулж байгаа нь цагаа олсон ажил юм. Энэхүү ажил амжилттай хэрэгжинэ гэдэгт эргэлзэхгүй байна. Та бүхний хэлсэн зөвлөмжийг анхааралтай даган ажиллах болно” гэлээ. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг орон нутагт тодорхойлох чиглэлээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хоёр аймаг сонгон дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд нийслэлд тогтвортой хөгжлийн зорилтуудыг хотын хөгжлийн алсын хараатай уялдуулан биелүүлэх бэлтгэл ажил болон хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргахад техникийн туслалцаа авч хэрэгжүүлэх чиглэлээр Улаанбаатар хотын зүгээс хүсэлт тавьж хамтран ажиллахаар боллоо.

ҮЗЭЛ БОДОЛ

# ХЭН ЮУ ХЭЛЭВ












**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Эхчүүдийн жилдээ ганц удаа авч байгаа тэтгэлгийг нэмэх хэрэгтэй гэж үзээд хуулийн төсөл өргөн барьсан. I одонтой ээж жилдээ 200.000 төгрөг авч байгааг 1,000,000 төгрөг, II одонтой ээж 100.000 төгрөг авч байгааг 500.000 төгрөг болгохоор оруулж өгсөн. Харамсалтай нь энэ удаагийн Их хуралд хэлэлцүүлж чадсангүй. Гэхдээ би үүнийхээ төлөө тууштай явна. Өндөр хөгжилтэй орнуудад ч хүн ам зүйн бодлогоо дэмжсэн олон ажил хийдэг. Жишээлбэл, Арабад нэг хүүхэд төрөхөд ээжийнх нь дансанд төр 70.000 долларыг шилжүүлж байна. Энэ мөнгөөр та хүүхдээ сайн хүн болгож хүмүүжүүлээрэй гэж. Бидэнд тийм боломж байхгүй ч гэсэн хөнжлийнхөө хэрээр хөлөө жийгээд хүн бэлдээд байгаа хүмүүсийнхээ хөдөлмөрийг үнэлгээтэй болгоосой гэж боддог" хэмээн ярьжээ. Мөн эрхэм гишүүний хувьд Гэр бүлийн тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж байсан билээ. Энэ хуулийн гол заалт нь хүүхэд төрсөн цагаасаа эхлээд өмчийн эзэн байх. Гэр бүлийн гишүүн бүхэн хариуцлагаа үүрдэг байх тухай асуудлыг тусгажээ. Аав гэр бүл орхиж, салсан тохиолдолд Гэр бүлийн хуульд заасны дагуу хүүхэд эхнэртээ нийт өмчийнхөө 80 хувийг үлдээх юм байна. Дундын өмчлөлд бий болсон үйлдвэрээ таван хэсэг хуваана гэсэн үг аж. Энэ хууль нийгэмд хүлээлт үүсгэж байгаа төдийгүй, үр хүүхдээсээ өөр үлдэж хоцрох өмчгүй үлдсэн олон эмэгтэйчүүд хуулийг батлуулахыг хүсч буй юм.

...Н.Мягмар "Хэвлэл мэдээллээр шуугиад байгаа шиг их хэмжээний хар тамхи оруулж ирээд зарах гэж байгаад баригдсан гэх мэт мэдээллүүд бол ташаа мэдээлэл юм шиг байсан. Бид үнэндээ үнэн худал гэдгийг хэлж мэдэхгүй. Энэ талаар хууль хяналтын байгууллагаас олон нийтэд мэдээлэл өгөх байх гэж бодож байна...

## М.Зоригт: Гурван улсын транзит туршилтын тээвэр наймдугаар сард болно

-Монгол, Хятад, Орос улсын хооронд хийх транзит тээврийн асуудал эдийн засаг, олон улсын харилцаа гээд олон талаас анхаарлын төвд байгаа. Тэгвэл энэ асуудлыг гурван улсын Зам тээврийн сайд нар ОХУ-ын Улаан-Үд хотод ярилцжээ. Манай талаас оролцсон Зам тээврийн сайд М.Зоригт уулзалтын үр дүнгийн талаар байр сууриа илэрхийлжээ. М.Зоригт сайд "Гурван тал өөр өөрийн саналыг дэвшүүлж хэлэлцсэний эцэст наймдугаар сарын 15-20-ны өдөр Тяньжинаас Улаан-Үд хүрэх туршилтын тээврийг хийхээр тохиролцсон. Үүнд чингэлэг, битүү тент, хөргүүр бүхий гурваас доошгүй ачааны авто машиныг улс бүхэн оролцуулахаар боллоо. Түүнийг дагалдаж эмнэлгийн анхан шатны тусламж, автомашинд засвар үйлчилгээ үзүүлэх баг, хэвлэл мэдээллийнхэн болон төлөөлөгчдөд зориулсан том оврын автобус унаа зэрэг өргөн бүрэлдэхүүнтэйгээр аялалд оролцоно. Үүнээс гадна аюулгүй байдлыг хангах цагдаагийн хамгаалалт, хооллож ундлах, амрах байр буудлыг тухайн улс өөрийн нутаг дэвсгэр дээр хариуцаж ажиллахаар тохиролцсон. Монгол, ОХУ олон улсын Тээврийн конвенцид нэгдчихсэн. Энэ нь хил, гаалиараа түргэн шуурхай нэвтрүүлэх үүрэг хүлээдэг баримт бичиг л дээ. Хятад улс үүнд нэгдэхээр ярилцаж байгаа юм билээ. Наймдугаар сар гэхэд гарынүсэгзураадбаталгаажуулчихвал асуудалгүй болно. Туршилтын тээвэрт оролцох бүх хүний визний асуудлыг талууд яаралтай, хурдан шуурхай шийдэж өгөх талаар тохиролцоонд хүрсэн. Зургад¬угаар сарын 30-ны дотор өөрийн орны нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх маршрут, хөтөлбөрийг боловсруулж талуудад хүргүүлэх юм" гэв.

## Л.Цандэлэг: З.Энхболд намынхаа олон жирийн гишүүдийг итгэлийг алдлаа

-АН-ын ҮЗХ өнгөрсөн баасан гарагт хуралдаж УИХ-д нэр дэвшигчдээ тодруулсан билээ. Тэгвэл энэ хурал эхнээсээ дуусах хүртлээ асуудал, маргаан дагуулсан гэдгийг АН-ын гишүүн Л.Цандэлэг "dorgio.mn" сайтад өгсөн ярилцлагадаа онцолжээ. Тэрбээр, "АН-ын ҮЗХ Төрийн ордонд 18.00 цагт эхэлнэ гэсний дагуу бүх хүн цугласан. Сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигчийг улс төрийн намууд 27-ны 00:00 цагаас өмнө нэр дэвшигчийг зарлах ёстой. Гэтэл 23:00 цагийн орчимд намын дарга бие хамгаалагч нартайгаа их сүртэй гэнэт орж ирсэн. Шууд шүүхийн тогтоол уншиж байгаа юм шиг барьж орж ирсэн цаасан дээрээсээ бүх тойрогт өөрсдийнхөө зоосон хүмүүсийг нэрлээд явсан. Гэтэл 6-7 хүний нэр нь өөрчлөгдсөн. 3-4 хүний тойргуудыг сольсон. 5-6 хүний нэрийг хасаад хаясан байдалтайгаар орж ирсэн. Нэр дэвшигчдийн нэрийг хэлээд З.Энхболд хамгаалагч нартайгаа гараад зугтчихсан. Тэгээд хаалганы цаана гараад мэдэгдлээ хийчихсэн. Нэлээд олон хүний намдаа итгэх итгэл буурч, намаасаа гарахаар болсон. З.Энхболдын нэр дэвшүүлсэн 10 гаруй хүн нь намын анхан шатны байгууллагад нэр хүнд нь уначихсан. Нэгаймагт нэр дэвшиж гишүүн болчихоод тэндээ юу ч хийгээгүй, намын листээр гишүүн болно гэж найдаад хуйвалдаж байсан хүмүүс тойргоосоо хөөгдөөд ирэхээрээ энд тэнд нэр дэвшиж байна. 20 гаруй жил АН-ын гишүүн явлаа. Шударга хэлдэг олон хүнийг намаас шахаад шахаад гаргалаа. Би АН-ын гишүүн, ҮЗХ-ны гишүүн. Би Дарханаас нэр дэвших хэрэгтэй байна аа, манай тариаланчид ийм хүсэлтэй байна гээд З.Энхболд даргатай уулзахад "Дарханд бол амжихгүй ээ. Дарханы суудлыг бид аль хэдийнэ хуваарилчихсан. Чи газар тариалангийн бүсэд очиж ажилла" гэсэн. Дархан аймгийн ҮЗХ-ны гишүүн хүн Сэлэнгэд очоод өөрийгөө таниулаад тэр хурлаас гарч ирнэ гэдэг процедурын хувьд хүнд л дээ. Би тэнд очоод хүмүүстэй уулзаад гарч ирж байхад намайг дуучин бүсгүйгээр сольсон байна билээ.

## Л.Байзада: Тэр эмэгтэй бидэнд тэвчиж боломгүй сонин зан гаргаж байсан

-Шүрээр утасны дугаар хэлхэж охиныхоо эмчилгээний зардлыг олж байгаа М.Наранмандах бүсгүйн талаар цахим ертөнцөөр багагүй шуугиж, энэ бүсгүйд туслах гэсэн хандивын аян шат шатанд өрнөсөн билээ. Тэгвэл охины ээжид эмчилгээний зардал олоход нь туслах аяныг "Латиф" сангийн тэргүүн дуучин Л.Байзада туслахаар болж "Зүрхний бяцхан Сувд" нэртэй хандивын тоглолтыг өнгөрсөн дөрөвдүгээр сарын 25-нд зохион байгуулсан билээ. Гэвч тоглолт дууссаны дараа Л.Байзада нэг ч төгрөгийн хандивыг өгөөгүй талаар охины ээж хэвлэл мэдээлэлд ярилцлага өгсөн юм. Тэгвэл, өвчтэй охины ээжийг залилсан гэх Л.Байзада энэ талаар дуугарсан нь олны анхаарлыг татлаа. Тэрбээр, "Тоглолт төлөвлөсөн өдөр, цагтаа болох ёстой газраа болсон. Энэ бүхнийг сан хариуцаж амжилттай хэрэгжүүлсэн. Тоглолтод тасалбар дээр бичсэн хамтлаг дуучдаас 70-80 хувь нь оролцож, үнэ төлбөргүй ая дуугаа хүргэсэн. Энд хамтлаг дуучин бүр тодорхой ханшаар тоглолтод оролцдогийг хэлүүлэлтгүй мэдэж байгаа гэж найдъя. Тоглолтын дундуур охины ээж хөтөлбөрт дурьдагдаагүй СУИС-ийн оюутнуудыг дур мэдэн оруулсан нь бидний ажлыг хүндэтгээгүй хэрэг болсон гэж болно. Мөн бид нэг ч мөнгө аваагүй, цалин хөлсгүй чин сэтгэлээсээ ажилласан. Тоглолтод охины ээжээс мөнгө авсан. Харин тоглолт болох УБ паласын төлбөрийг бид сангаасаа гаргасан. Бид асрамжийн газрын хүүхдүүдэд өгсөн билетийн мөнгөө уг бүсгүйд өгнө. Ер нь тэр эмэгтэй анхнаасаа бидэнд үл итгэсэн, захирангуй харьцаж эхэлсэн. Биднээс өөр хүн бол тэвчимгүй үйлдэл олон гаргаж, тоглолтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах, дуучдыг өөрийн хүслээр сольж байлаа. Хэрвээ алдаа мадагтай асуудал байвал шүүхээр шийдүүлэхэд бэлэн" хэмээн мэдэгдсэн байна.

## Н.Мягмар: Их хэмжээний хар тамхи зарах гэсэн мэдээлэл худлаа юм шиг байна лээ

-Монголын залуусын сонсох дуртай хамтлагийн нэг болох "Guys" хамтлагийн гишүүн Х.Бат-Ундрал хар тамхины хэрэгт холбогдсон нь өнгөрөгч долоо хоногт олны анхаарлыг татаж, хамтлагийн нэр хүндийн асуудал яригдаж эхэлсэн. Гэвч тус хамтлагийнхан энэ талаар мэдээлэл хийж манай хамтлагаас гарсан гэсэн мэдээллийг өгснөөр хэвлэл мэдээллээр тэдний хүн чанарын тухай асуудал сэдэв болон яригдаж, улмаар хэрэгт орсон нэгнээ өмгөөлж гарахын оронд өөрсдөөсөө холдууллаа гэх шүүмжлэл газар авсан билээ. Тэгвэл хамтлагийн ахлагч Н.Мягмар энэ асуудлаар өгсөн ярилцлага олны анхаарлыг татлаа. Н.Мягмар "Хэвлэл мэдээллээр шуугиад байгаа шиг их хэмжээний хар тамхи оруулж ирээд зарах гэж байгаад баригдсан гэх мэт мэдээллүүд бол ташаа мэдээлэл юм шиг байсан. Бид үнэндээ үнэн худал гэдгийг хэлж мэдэхгүй. Энэ талаар хууль хяналтын байгууллагаас олон нийтэд мэдээлэл өгөх байх гэж бодож байна. Б хамтлагаасаа гарсан хэдий ч бид нарын найз нөхдийн холбоо хэвээрээ л байгаа. Тиймээс юу болсон яасан талаар араас нь асууж сураглаж явсан. Ингэхдээ яг хэвлэлд бичигдэж байгаа шиг тийм зүйл болоогүй гэдгийг мэдэж авсан. Б одоогоос бараг сар гаруйн өмнө хамтлагаасаа гарсан байсан. Тухайн хүний маань сонголтоор өөрийнх нь ажил амьдралын шаардлагаар гарах хүсэлтэй байсан. Тиймээс хүсэлтийг нь хүлээж авсан. Японд улсад хийсэн аялан тоглолтдоо гурвуулаа явсан. Одоо уран бүтээлээ гурвуулаа хийж байна" хэмээн ярьжээ.

Дугаарын **60** мөр

## Зусланд амраахын зэрэгцээ эрүүл мэндийг нь нэг шалгуулчих

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Харин нийслэлийн Засаг даргын захирамжаар ногоон бүсийн 24 зуслангийн бэлтгэл ажил, Монгол Улсын стандартын хэргжилтийг хангуулах шалгалтыг ч хийгээд амжиж. Энэ бүх бэлтгэлээ базаасан болохоор Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн газраас энэ зун ажиллах хүүхдийн зуслангуудыг олон нийтэд танилцуулсан. Ерөнхийдөө үйл ажиллагаа явуулах эрх бүхий зуслангуудын зөвшөөрлийг жил бүрийн зургадугаар сарын эхээр нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу НЗДТГ, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Улаанбаатар хотын цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар гэсэн зургаан байгууллагаас бүрдсэн ажлын хэсэг дээрх сургалт, шалгалтыг явуулсны дараа олгодог учиртай. Гэсэн хэдий ч өнгөн дээрээ шалгалтад тэнцчихээд, цаана нь стандарт хангаагүй байж мэдэх тул сэрэмжтэй байхад илүүдэхгүй биз. Учир нь шалгалтад тэнцсэн гэх зуслангуудад хоолны хордлогын өвчлөл жил тутам буурахгүй гарах болсон талаар эх сурвалжийн мэдээлэл батлаад байгаа юм. Түүгээр ч барахгүй 2014 онд гэхэд л хүүхдийн амралт дөнгөж эхэлж байхад "Ундраа" зуслангийн амрагч 20 гаруй хүүхэд хоолны хордлогод орж, түргэн тусламжийн машинаар хотын эмнэлгүүдэд хүргэгдэж ирж байсан гашуун түүх бийг мартах учиргүй. Нэг л удаагийн хоолны хордлого нэг насны өвчинг тээж ирдэг гэдэг. Тиймээс бяцхан хүүхдийг хүмүүжүүлэх нэрээр хордуулж байгаа газруудыг "сайн чангалах" шаардлагатай юм. Үүнээс гадна энэ жилийн хувьд улаанбурхан, гар, хөл амны өвчний дэгдэлт их байгаа. Тиймээс зуслангуудад тавих хараа хяналтаа урьд урьдынхаас илүүтэй чангаруулж, эрүүл ахуйг дээд зэргээр сахиулах шаардлагатай байна. Бөөн бөөнөөрөө өвдөж, хордсоных нь дараа хариуцлага ярьж суухын оронд өвдөж, хордохоос нь өмнө арга хэмжээ авах нь зүйн хэрэг биз. Нөгөө талдаа эцэг, эхчүүд ч хариуцлагатай байх хэрэгтэй. Уг нь зуслангууд амрагч хүүхдүүдийг хүлээн авахдаа эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх шинжилгээнд хамрагдсан эсэхийг шалгадаг. Гэтэл эцэг, эхчүүд хүүхдээ харьяа дүүргийн Эрүүл мэндийн төвд аваачиж үзүүлэхгүй танил хөнгөн хийсвэр хандаж, эрүүл мэндийн бичгийг танил талаасаа авчихдаг гэм бий. Эсвэл хуурамч бичиг тодорхой хэмжээний өртөгтэйгээр худалдан борлуулдаг этгээдүүдээс авчихдаг гээд асуудал их байдаг. Нэг удаа амраах гэсэн биш нэг насны өвчтэй болгочих вий гэсэн болгоомжлол эцэг, эхчүүдэд үнэндээ алга. Ер нь бол хүүхдүүдийг зусланд амраахын тулд www.child.gov.mn сайтаас эрүүл мэндийн хуудсыг татан авч, харьяа дүүргийн Эрүүл мэндийн төвөөр бөглүүлэх хэрэгтэй. Харин хувийн болон харьяаллын бус эмнэлгээр бөглүүлбэл хүчингүйд тооцохыг албаны хүн нь анхааруулсан шүү. Мөн зусланд амрах хүүхдүүд дотор, арьс, сүрьеэ, цагаан хорхой болон шээсний шинжилгээ өгөх юм билээ. Харин өсвөр насныхан буюу 16-18 насныхан ДОХ, бэлгийн замын халдварт өвчний шинжилгээ өгөх шаардлагатай гэсэн. Тиймээс л эцэг, эхчүүд өсвөр насны хүүхдүүддээ анхаарал хандуулах шаардлагатай болоод байгаа юм. 14 настай охин хүүхэд төрүүлж байгаа өнөө цагт зусланд амрахаар явахад нь ч сэрэмжлэх хэрэгтэй болох нь. Уг нь эцэг, эхчүүд л хүүхдүүдээ зусланд амраахын зэрэгцээ эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт биечлэн хамруулж, хүүхдийнхээ эрүүл мэндийг нэг удаа шалгуулчихад хэцүү зүйл үгүй мэт санагдана.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## З.Энхболд хил дамнан заавар өгсөөр байна

АН-ын ҮЗХ хуралдахдаа намын хорооноос хурлаар нэр дэвшүүлж оруулж ирсэн хүмүүсийг дарга болон, фракциудын тохироогоор намын дүрэм, Сонгуулийн хууль зөрчин хүч түрэн өөрчилсөн. Ингээд өөрсдийн тохирооны хүмүүсээ нэр дэвшүүлсэн юм. Чингэлтэй дүүргийн намын хорооноос зуун хувийн саналаар нэр дэвшүүлэхээр оруулсан Б.Батбаатарыг хүчээр нэр дэвшүүлээгүй. Б.Батбаатар албан ёсоор намаас гарах өргөдлөө өгч Иргэний хөдөлгөөний намаас З.Энхболдын дэвшиж байгаа Баянгол дүүргийн 70 дугаар тойрогт нэр дэвших болсноос болж, АН-ын дарга бүх л чадлаараа эсэргүүцэж байна. Тэр ч бүү хэл СЕХ-нд бичиг хүргүүлж, нэр дэвшүүлэхгүй байх, өгсөн бичиг цаасанд нь ямар нэг дутуу зүйл байна уу сайтар шалга, эс бөгөөс "Иргэний хөдөлгөөний намын нэр дэвшүүлэх хуралдааныг хүчингүй болго" гэж шахжээ. Ингээд өөрийнх нь гол саналыг хуваах байх гэж айж байгаа Б.Батбаатарыг дэвшүүлэхгүйн тулд бүхий л аргыг хэрэглэ гэж Японд айлчилж байгаа хэрнээ хил дамжин заавар өгсөөр байна.

## "Азийн форум"-ын талаар тайлагнав

Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн өнгөрсөн сарын сарын 30-31-нд Япон улсад ажлын айлчлал хийжээ. Айлчлалын үеэр Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн Ерөнхий сайд Ш.Абэд бараалхаж, Японы Гадаад хэргийн сайд Ф.Кишида-тай хэлэлцээ хийж, "Никкэй" сонины газраас жил болгон зохион байгуулдаг "Азийн ирээдүй" форумд оролцож, Монгол Улсын гадаад бодлого, Зүүн хойд Азид хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар танилцуулж, илтгэл тавьсан байна. Өнгөрсөн онд болсон энэхүү форумын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч "Азийн форум" зохион байгуулах санаачилгыг дэвшүүлсэн. Тэгвэл энэ удаагийн уулзалтаар тус санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр монголын талаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны талаар тайлагнаж, бүс нутгийн орнуудын цаашдын хамтын ажиллагааны чиглэл, зорилтуудын талаар танилцуулжээ. Уулзалт, ярианы үеэр Монгол, Японы стратегийн түншлэлийг олон улс, бүс нутгийн талбарт гүнзгийрүүлэх, дээд, өндөр төвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалах, ирэх онд болох 45 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, энэ сарын 07-ноос хүчин төгөлдөр болох Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд Японы талтай нягт хамтран ажиллах, мөн бүс нутаг, олон улсын тавцан дахь хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон байна.

МЭДЭЭЛЭЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# “1992 ОНЫ НЭГДСЭН ОЙЛГОЛТ” УЛС ТӨРИЙН ҮНДСЭН СУУРИЙГ БАРИМТЛАН, ХОЁР ЭРГИЙН ХАРИЛЦААНЫ ЭНХ ТАЙВНЫ ХӨГЖЛИЙГ ХАМГААЛНА

Энэ жилийн тавдугаар сарын 20-ны өдөр, Тайваний шинэ удирдагч Цай Инвэнь тангараг өргөхөөр тавьсан илтгэлд 1992 онд Хятадын эх газрын хоёр эргийн харилцааны нийгэмлэг болон Тайваний хоолойн солилцооны сан (цаашид хоёр эргийн хоёр байгууллага гэх) яриа хэлэлцээр хийж, хэд хэдэн нэгдсэн ойлголтод хүрсэн талаар дурьдан, одоогийн мөрдөгдөж буй журам болон холбогдох тогтоомжийн дагуу хоёр эргийн харилцааны асуудлыг зохицуулж, нэгэнт байгаа улс төрийн үндсэн суурин дээр хоёр эргийн харилцааны энх тайвны хөгжлийг үргэлжлүүлэн хөгжүүлнэ гэдгээ илэрхийлэв. Гэвч, хоёр эргийн элэг нэгтнүүдийн хамгийн ихээр анхаарч буй хоёр эргийн харилцааны статусын энэхүү үндсэн асуудал дээр бүрхэг байр суурь барьж, “1992 оны нэгдсэн ойлголт” болон түүний зангилаа утга ойлголтыг илт хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд хоёр эргийн харилцааны энх тайван, тогтвортой хөгжлийг хамгаалахаар тодорхой санал дэвшүүлсэнгүй. Энэ бол бүрэн хариулаагүй шалгалтын тест байна. Үүнд, миний бие найз нөхөд та бүхэнд өөрийн санал бодлоо илэрхийлэхэд бэлэн байна.

Дэлхий дээр нэг л Хятад байдаг. Тайвань бол эрт дээр үеэс Хятадын нутаг дэвсгэрийн салшгүй нэгэн хэсэг, Тайваний хоолойн хоёр эрэг нь нэг л Хятадад харьяалагддаг. Энэ бол олон улсын нийгэм дэх нэгдсэн ойлголт. Мөн Монголын талын тууштай баримталдаг байр суурь юм. 20 гаруй жилийн өмнө, Хятадын эх газрын хоёр эргийн харилцааны нийгэмлэг болон Тайваний хоолойн солилцооны сан “Хоолойн хоёр эрэг нэг Хятадын зарчмыг баримтлах” нь “1992 оны нэгдсэн ойлголт”-д хүрч хоёр эргийн харилцааны хөгжилд үндсэн суурийг тавьж өгсөн юм.

2008 оноос хойш хоёр эрэг нь “1992 оны нэгдсэн ойлголт”-ыг баримтлах, “Тайванийг тусгаарлуулах”-ыг эсэргүүцэх хамтын улс төрийн суурин дээр хоёр эргийн харилцааны энх тайвны хөгжлийн замыг нээсэн. 2015 оны арваннэгдүгээр сард, хоёр эргийн удирдагчид 66 жилийн туршид анх удаа уулзалт хийж, хоёр эргийн харилцааны түүхэн хуудсыг нээсэн. Хоёр эргийн хэрэг хариуцсан байгууллагуудын удирдлагууд олон удаа уулзалт хийж, байнгын утсан шугам байгуулсан. Хоёр эргийн хоёр байгууллагын хэлэлцээр үр дүнтэй болж, 23 баримт бичигт гарын үсэг зурсан. Хоёр эргийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа тогтвортой урагшилж, хоёр тал “Хоолойн хоёр эргийн эдийн засгийн хамтын ажиллагааны суурин хэлэлцээр”-т гарын үсэг зурж, эх газар нь Тайваний хамгийн том худалдааны түнш болон худалдааны ашгийн үүсгэвэр болсон. Хоёр эргийн ард иргэд олноор харилцан зорчиж, 2015 онд хоёр эргийн иргэдийн солилцоо давхардсан тоогоор 10 сая орчимд хүрсэн. Бид Тайваний элэг нэгтнүүдийн аз жаргалыг анхаарч, Тайваний талыг нэг Хятад гэх зарчмын дагуу зохистой хэлбэрээр Олон улсын иргэний нисэхийн байгууллага болон Дэлхийн эрүүл мэндийн ассемблейд оролцуулсан. Саяхан бид энэ зарчмынхаа дагуу Тайваний талын төлөөлөгчдийг энэ жилийн Дэлхийн эрүүл мэндийн 69 дүгээр ассемблейд оролцуулсан. Хоёр эргийн харилцааны энх тайвны хөгжил хоёр эргийн ард түмний язгуур ашиг сонирхолд нийцдэг бөгөөд энэхүү таатай байдлыг хамгаалах нь хоёр эргийн ахан дүүс, хилийн чанад дахь иргэд болон олон улсын нийгмийн нийтлэг хүсэл юм.

Ши Жиньпин даргын онцолсончлон, бид Тайваний чиглэлийн бодлогыг тодорхой, тууштай баримтлах бөгөөд энэхүү бодлогыг Тайваний улс төрийн байдлаас болж өөрчлөхгүй. Хоёр эргийн харилцааны энх тайвны хөгжлийг хамгаалах хамгийн гол үндэс нь “1992 оны нэгдсэн ойлголт” гэх улс төрийн үндсэн суурийг хамгаалахад оршино. “1992 оны нэгдсэн ойлголт” нь хоёр эргийн харилцааны үндсэн статусыг тодорхойлж, эх газар болон Тайвань нь бүгд нэг Хятадад харьялагддаг, хоёр эргийн харилцаа нь улс хоорондын харилцаа биш гэдгийг илэрхийлсэн. “1992 оны нэгдсэн ойлголт” нь хоёр эргээс эрх олгон батлуулж, хоёр эргийн удирдагчид нотолсноор хоёр эргийн харилцааны энх тайвны хөгжлийн тулгуур болсон юм. 20 жилийн туршид хоёр эргийн харилцааны хөгжлийн явц нь нэг Хятад гэх зарчмын улс төрийн үндсэн суурийг баримталснаар хоёр эргийн харилцаа тогтвортой хөгжиж, Тайваний хоолойн нөхцөл байдал энх тайван байж, хоёр эргийн ард түмэн үр шимийг нь хүртэж чадна гэж харуулсан. Харин нэг Хятад гэх зарчмыг зөрчвөл хоёр эргийн харилцаа болон Тайваний хоолой хурцадмал нөхцөл байдалд орно. Гэвч Тайваний шинэ удирдагч хоёр эргийн харилцааны статус энэхүү чухал зарчмын асуудалд тодорхой байр суурь илэрхийлээгүй, тодорхой хариулт өгөөгүй нь хоёр эргийн харилцааны тогтвортой хөгжилд зайлшгүй хохирол учруулах болно.

“Тайванийг тусгаарлуулах” нь ирээдүй байхгүй, мөн Тайваний ирээдүйн хувьд нэгэн сонголт байх боломжгүй. Энэ бол түүхийн эцсийн дүгнэлт юм. Энэ жилийн гуравдугаар сарын 5-нд, Ши Жиньпин дарга онцлон тэмдэглэхдээ, “Бид ‘Тайванийг тусгаарлуулах” бүх хэлбэрийн үйлдлийг эрс шийдэмгийгээр таслан зогсоож, улсын бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах болно. Энэ бол Хятадын бүх ард түмний нийтлэг хүсэл болон тууштай санаа зориг, мөн бидний түүх болоод ард түмэндээ өгсөн өндөр хариуцлагатай амлалт, тэднээс хүлээсэн үүрэг юм” “Тайванийг тусгаарлуулах” нь Тайваний хоолойн энх тайван болон хоёр эргийн харилцааны энх тайвны хөгжлийн хамгийн том гай гамшиг. “Тайванийг тусгаарлуулах”-ыг хийвэл Тайваний хоолой энх тайван, тогтвортой байх боломжгүй болно. Хоёр эргийн ард түмний нийтлэг санаа зориг нь зөрчигдөшгүй юм. Өнөөдөр бидний улс орны бүрэн эрх болон нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах байр суурь өөрчлөгдөөгүй бөгөөд, илүү чадвартай байж, бүх хэлбэрийн “Тайванийг тусгаарлуулах” гэх салан бутаргах үйл ажиллагаа болон бодлогыг эрс таслан зогсооно.

Хоёр эргийн харилцааны энх тайвны хөгжлийн таатай нөхцөл байдал нь амаргүй бий болсон. Хоёр эргийн элэг нэгтнүүд үүнийг хамтдаа хамгаалах хэрэгтэй юм. Бидний Тайваний чиглэлийн бодлого нь хоёр эргийн ард түмний үндсэн гол ашигт болон хоёр эргийн харилцааны энх тайвны хөгжлийн чиг хандлагад нийцэж байдаг. Тайваний элэг нэгтнүүд бол бидний цус нэгт ахан дүүс, ямар ч хүч биднийг салгаж чадахгүй. Бид цаашдаа хоёр эргийн элэг нэгтнүүдийн аз жаргал болон халуун дотно сэтгэлийг нэмэгдүүлэхэд үргэлжлүүлэн хүчин чармайж, хоёр эргийн элэг нэгтнүүдийн харилцааг улам өргөжүүлж, бүхий л салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, хоёр эргийн эдийн засаг нийгмийн хөгжлийг гүнзгийрүүлж, хоёр эргийн хувь заяаны нэгдлийг хамтдаа бүтээн байгуулж, гар гараасаа барин Хятад үндэстний агуу их сэргэн мандалтыг биелүүлэх болно.

Ирээдүй нь сонгох замаас шалтгаална. Нэг Хятадын зарчмын нийтлэг улс төрийн үндэс суурийг хамгаалах, эсвэл “Тайвань, Хятадын харилцаа бол улс улсын харилцаа”, “Хятадын эх газар болон Тайвань хоёр улс” гэх “Тайванийг тусгаарлуулах” байр суурийг баримтлах, хоёр эргийн харилцааны энх тайвны хөгжлийн замаар үргэлжлүүлэн явах, эсвэл Тайваний хоолойн хурцадмал байдлыг дахин өдөөн үүсгэх, хоёр эргийн элэг нэгтнүүдийн харилцаа болон аз жаргалыг дээшлүүлэх, эсвэл элэг нэгтнүүдийн хоорондын сэтгэлийн уялдааг таслуулж, улмаар тэдний язгуур ашгийг хохироох эдгээр чухал асуудлуудад Тайваний шинэ эрх баригч илүү бодит алхмаар тодорхой хариултыг өгч, түүх болон ард түмэнд шалгуулах хэрэгтэй. Нэг Хятадын зарчим бол хоёр эргийн харилцааны энх тайвны хөгжлийн тулгуур. Энэ зарчмыг баримталснаар цаг үеийн хөгжлийн хандлагыг дагаж хоёр эргийн харилцаа энх тайван хөгжих боломжтой. Хэрвээ түүхийн урсгалыг сөрөн хөдөлж, хоёр эргийн харилцааны нийтлэг улс төрийн үндсэн суурийг эвдэлж, Тайваний хоолойн төсөөлшгүй нөхцөл байдал үүсгэж, Тайваний хоолой болон бүс нутгийн энх тайван тогтвортой байдалд аюул учруулбал үүний хариуцлагыг зөвхөн сэдэн өдөөгч хүлээн авч хариуцах болно.

*Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд*

ШИН ХАЙМИН


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016 оны 06 дугаар сарын 02
**Тендер шалгаруулалтын нэр:**
**БАГЦ 01:** “Компьютер, хэвлэгч, хувилагч нийлүүлэх”
**БАГЦ 02:** “Ухаалаг самбар, дижитал камер, проректор, зарлал уншуулах төхөөрөмж нийлүүлэх”
**БАГЦ 03:** “Сервер, тог баригч UPS нийлүүлэх”
**БАГЦ 04:** “Дараалал зохицуулах машин нийлүүлэх”
**БАГЦ 05:** “Карт хэвлэгч нийлүүлэх”
**Тендер шалгаруулалтын дугаар:** 14/2016-Хд

МИАТ ХК эрх бүхий тендерт оролцогчдоос 5 багц бүхий компьютерийн тоног төхөөрөмж нийлүүлэх тухай битүүмжлэл бүхий тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээр гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Төлбөрийг бэлнээр МИАТ ТӨХК –ийн төв байрны кассанд тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил 100,000,000 төгрөг

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 60,000,000 төгрөг

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2014он, 2015 он

**Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** 120,000,000 төгрөг

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** шаардлагагүй

Тендерийн хамт Багц 01 – 1069000 төгрөг, Багц 03 – 940,000 төгрөг, багц 05 - 400,000, төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 10.00 цаг –аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 10.30 цаг -т нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй**
**Дотоодны давуу эрх тооцохгүй**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**МИАТ ТӨХК**
**Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа, МИАТ ТӨХК-ийн төв байр Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот өрөө**
**Утас: 70049860, Факс: 70049919**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016 оны 06 дүгээр сарын 02
**Тендер шалгаруулалтын нэр:** Нэг удаагийн хэрэглээний элсэн чихэр, кофены сүү нийлүүлэх
**Тендер шалгаруулалтын дугаар:** 06/2016-ХД

МИАТ ХК эрх бүхий тендерт оролцогчдоос Олон улсын болон орон нутгийн нислэгийн зорчигчдын үйлчилгээнд Нэг удаагийн хэрэглээний элсэн чихэр, кофены сүү нийлүүлэх тухай 2 багц бүхий битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

**Багц 1** Нэг удаагийн хэрэглээний элсэн чихэр /5гр, бор, цагаан/ нийлүүлэх

**Багц 2** Нэг удаагийн хэрэглээний кофены хуурай /3-5гр/ болон шингэн сүү /7,5-10гр/ нийлүүлэх

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар МИАТ ХК-ийн төв байрны кассанд бэлнээр тушааж, Хангамжийн хэлтсийн 103 тоот өрөөнөөс худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил 100,000,000 төгрөг

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 100,000,000 төгрөг

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2

**Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** 200,000,000 төгрөг

Тусгай зөвшөөрөл шаардлагагүй.

Тендерийн хамт багц 1-д 440,000 төгрөгийн, багц 2-т 1,960,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 06 дугаар сарын 17-ны 10.00 цаг-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 10.30 цаг -т нээнэ.

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**МИАТ ХК**
**Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа**
**МИАТ ХК-ийн төв байр Хангамжийн хэлтсийн 103 тоот өрөө**
**Утас: 70049860 Факс: 70049919**

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Налайх дүүргийн Боловсролын хэлтэс нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Налайх дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудад шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн- ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

**Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:**

**Багц 1-** Налайх дүүргийн “Эрдмийн-Оргил” цогцолбор сургуулийн дотуур байранд шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлэх

**Багц 2-** Ерөнхий боловсролын сургуулийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн танхим”-д сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлэх

Үнийн санал авах баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50.000 /тавин мянга/ төгрөгөөр худалдан авч болно.

Төлбөрийг Төрийн сан банк- 200415413 тоот дансанд тушаана.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн дотор хүчинтэй байна

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2016 оны 06 сарын 13-ны өдөр 14:00 цаг-аас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2016 оны 06 сарын 13-ны өдрийн 14:40 цаг -т нээнэ.

**Дотоодны давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо, Хуульчдын гудамж, Тохижилт үйлчилгээний компани ОНӨААТҮГ-ын байр, Худалдан авах ажиллагааны алба Мэргэжилтэн Г.Ариунзаяа Утас:7023-2788**

# ЭНТЕРТАЙНМЕНТ

УРАН БҮТЭЭЛЧ

Н.БАТЗАЯА

"Night of ballet" олон улсын балетын фестиваль тав дахь жилдээ буюу энэ сарын 4-нд Corporate and Convention центрт болно. Тоглолтын талаар Бостон балет компанийн гоцлол бүжигчин, МУГЖ, Д.Алтанхуягтай ярилцлаа.

# Д.Алтанхуяг:



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# ЗАЛУУ ХҮНИЙ ДҮРЭЛЗСЭН ЭРЧ ХҮЧЭЭР БАЛЕТЫН УРЛАГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ

**-"Night of ballet" олон улсын фестивалийг тав дахь жилдээ зохион байгуулах гэж байна. Энэ удаагийн тоглолт ямар онцлогтой болох вэ?**

-"Монголын балетын хөгжил сан", "Night of ballet" олон улсын фестивалийг зохион байгуулж эхлээд таван жил болсон байна. "Night of ballet" олон улсын балетын наадам нь бид эх орон, түүх соёл, өвөг дээдсээрээ бахархахын зэрэгцээ дэлхийн орчин цагийн соёл, урлагтай хөл нийлүүлэн алхаж, сонгодог урлагийг мэдэрч, ойлгож, дэмжиж, чадаж байгаагийн нэг илэрхийлэл юм. Энэ удаагийн наадам нь дэлхийн сонгодог урлагийн ноён оргил болсон бүтээлүүдийг олон орны бүжигчид Монголын тайзнаа амилуулж байгаа нь сонгодог урлагийн хөгжлийн төвшинг тодорхойлох нэр төрийн баталгаа болж байгаа гэдгээрээ онцлогтой. Тоглолтод манай орны бүжигчдээс гадна ОХУ, АНУ, Канад, Швед, Гүрж, БНХАУ-ын шилдэг балетын театрын шилдэг гоцлол бүжигчид урилгаар ирж оролцож байгаа. Мөн Монгол Улсад байдаг цорын ганц балетын театр болох ДБЭТ-ын бүжигчид, хувийн болон жижиг сургуулиудийн бүжигчид оролцоно. Ер нь наадам гэдэг утгаараа аль болох маш олон хүнийг оролцуулахыг хичээсэн.

**-Найман улсаас 10 бүжигчин ирж оролцож байгаа гэсэн. Ямар бүжигчид оролцож байна вэ. Өнгөрсөн жил оролцсон мөн анх удаагаа оролцож байгаа бүжигчид бий юу?**

-Манай тоглолтод дэлхийн хамгийн шилдэг театрын шилдэг гоцлол бүжигчид оролцож байна. Тухайлбал, АНУ-ын Бостон балетаас Дасти Баттон, Лаша Хозашвили нар ирсэн. Дасти Баттон бол Бостон балетын шилдэг гоцлол бүжигчдийн нэг. Эзэн хааны театрт Дэвид Бинтлигийн "Эр зориг" болон Натали Вейригийн "Бичигдээгүй" зэрэг жүжгийн гол дүрийг бүтээсэн. Мөн "Нойрсож буй гүнж", "Голт борын дагина", Жорж Баланчины "Symphony in C" гуравдугаар хэсэгт ахлах дүр бүтээсэн гээд маш их туршлагатай, алдартай бүжигчин. Харин Лаша Хозашвилигийн хувьд 2011 оны олон улсын балетын наадамд оролцож байсан. Мөн АНУ-ын Орландо балетын компанийн гоцлол бүжигчин Жосеф Гатти ирсэн. Түүнийг "Тэсрэгч бөмбөг" гэж нэрлэдэг. Учир нь тайзан дээр маш гайхамшигтай, хэний ч санаанд оромгүй тэсэрсэн үзүүлбэрийг хүмүүст хүргэдэг. Тэр мэргэжлийн шүүмжлэгчдээс байнга өндөр үнэлгээ авдаг. Манай наадамд анх удаа Канадын үндэсний балетын театрын гоцлол бүжигчин Наояа Эбэ өөрийн хамтрагч Сируи Лиутай хамт оролцоно. Энэ мэтчилэн балетын урлагт өөрийн гэсэн орон зайг олсон бүжигчид оролцож, нэгэн үдэш сонгодог урлагийн гайхамшгийг мэдрүүлнэ.

**-Энэ удаагийн наадмын гол үзүүлбэр нь юу байх вэ?**

-Бүгд нийлээд нэг тоглолт л доо. Харин тоглолтын үзүүлбэр бүр өөр өөрийн гэсэн онцлогтой. Жосеф Гатти өөрийн соло үзүүлбэрийг хийнэ. Мөн "Синсинати" балетын театрын гоцлол бүжигчин Родриго Алмаралес орчин үеийн сонгодог бүжиг бүжиглэнэ. Тэгэхээр үзүүлбэр болгон өөрийн гэсэн онцлогтой. Тэр, энэ нь илүү гэсэн зүйл байхгүй.

**-Таны хамтрагч Ч.Ганчимэг оролцоно гэсэн. ДБЭТ-аас өөр ямар бүжигчид оролцож байгаа вэ?**

-Манай ДБЭТ-аас найман бүжигчин оролцож байна. МУГЖ, Г.Цолмон, Ч.Ганчимэг, Б.Маруул, О.Анужинтөгс, С.Ганбат, А.Эрдэнэболд, Б.Баасансүрэн, Б.Батболд нар оролцоно. МУГЖ, Ч.Ганчимэг бид хоёр нэг ангид сурч байсан. Оюутан байхаасаа л бүжгийн хамтрагчид байлаа. Энэ удаагийн тоглолтод бид Уран хасыг хамтарч бүжиглэхээр болсон.

**-Гадаадаас оролцож байгаа бүжигчид манай улсад хэзээ ирсэн бэ. Тоглолт хоёр хоногийн дараа болно. Бэлтгэлээ хэр хийж байна вэ?**

-Тавдугаар сарын 1-нд ирсэн. Ирээд шууд л бэлтгэлдээ орсон. Монголын бүжигчидтэй хамтраад хоёр хоног бэлтгэл хийсэн. Ер нь энэхүү наадамд оролцож байгаа бүжигчид байнгын бэлтгэлтэй байдаг учраас бусад бүжигчидтэйгээ харилцан ойлголцоход хүндрэл байгаагүй. Бид олон улсын фестивалийг тав дахь удаагаа зохион байгуулж байгаа болохоор бага багаар туршлага хуримтлуулсаар байна.

**-Яагаад "Corporate and Convention" центрийн тайзыг сонгох болсон юм бэ?**

–"Night of ballet" бол олон улсын хэмжээний том наадам. Олон орны бүжигчид ирнэ. Тэд бүгд л Монголын балетын урлагийн хөгжлийг харна шүү дээ. Бүжигчдийн ур чадвараас гадна тайзны техник технологи гээд л. Би өнгөрсөн жил "Corporate and Convention" центрийн захирал Ганболд ахтай танилцаж, балетын наадмынхаа талаар ярилцсан. Тэгээд "Corporate and Convention" центрийн тайзан дээр тоглохоор болсон. Энэ тайзан дээр тоглох болсон шалтгаан нь гэвэл нэгдүгээрт, бид олон улсын чанартай наадам зохион байгуулж байгаа. Тэгэхээр бидэнд олон улсын жишигт нийцсэн тайз хэрэгтэй болно. "Corporate and Convention" центрийн тайз бол олон улсын жишигт нийцсэн, мэргэжлийн бүжигчдэд тохирсон тайз. Тиймээс л сонгосон. Бид олон улсын наадам зохион байгуулж байгаа болохоор бүх зүйл нь л тэр хэмжээнд нийцсэн байх хэрэгтэй. Хоёрдугаарт, ийм том наадам зохион байгуулна гэдэг амаргүй л дээ. Бүжигчдийг байрлуулах байр, хоол унднаас эхлээд ажил их. "Corporate and Convention" центр нь энэ бүгдийг өөртөө багтаасан. Энд манай бүжигчид бэлтгэлээ хийж, байрлаж, хооллож, тоглолтдоо орж байна. Энэ бүгд таалагдсан учраас сонгосон. Нэг талаараа Монголын балетын урлагийн хөгжил, нөгөө талаараа Монголын аялал жуулчлалын хөгжил ч гэсэн харагдана шүү дээ. Бүгдийг нь бодолцож үзсэн. Гэхдээ хамгийн гол нь мэргэжлийн тайз, орчин техник технологи, гэрэлтүүлэг чухал.

**-Та олон улсад эх орныхоо нэрийг гаргаад зогсохгүй Монголын балетын урлагийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа хүн. Өнгөрсөн хугацаанд "Монголын балетын хөгжил сан" олон ажлыг зохион байгуулсан. Хийсэн ажлаасаа танилцуулахгүй юу?**

-"Монголын балетын хөгжлийн сан" Монголд балетын урлагийг хөгжүүлэх, олон улсын чанартай тоглолт, тэмцээнийг зохион байгуулах, балетын боловсон хүчинг бэлтгэх зорилготой байгуулагдсан. Тэр ч утгаараа зорилгоо биелүүлэхийн тулд олон ажил хийлээ. Гэхдээ жижиг ч бай, том ч бай бидний зорилго адилхан. Нэг л зорилгын төлөө явж байгаа гэдгийг хэлмээр байна. Нэг жилд 37 өдөр 43 удаа тоглогддог "Бостон балет" компанийн "Цөмөөхэй" балетыг эх орондоо тавьсан. Цөмөөхэй балетад нийт 500 гаруй хүүхэд багачуудыг хамруулллаа. Энэ бол их том ажил л даа. Хүүхдүүдийг бэлдэхээс эхлээд л ажил ихтэй. Хүүхдүүдийг мэргэжлийн тайзан дээр мэргэжлийн уран бүтээлчидтэй хамт гаргана гэдэг амаргүй. Бидний хийсэн бүтээсэн зүйл бидний толгойноос их байгаа. Би зүгээр л нэг бүжигчин залуу. Гэтэл миний санаа бодлыг манай хамт олон байнга дэмждэг. Би маш их баяртай байдаг. Мөн бид гадаад, дотоодын үйл ажиллагаанд Монголын балетын урлагийн хөгжлийг сурталчлах, Япон болон АНУ-д залуу балетчдыг бэлтгэх ажлуудыг хэрэгжүүллээ. Бид энэ жилийн арваннэгдүгээр сарын 26-нд Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахаар төлөвлөсөн. Түүнчлэн 2017 оны гуравдугаар улиралд "Ази номхон далайн орнуудын олон улсын балетын анхдугаар тэмцээн"-ийг зохион байгуулна. Энэ мэтчилэн эх орондоо балетын урлагийг хөгжүүлэх, иргэдэд сонгодог урлагийн талаархи ойлголт өгөхөд чиглэсэн олон ажил хийж байна.

**-Манай улсын балетын урлагийн хөгжил дэлхийн бусад оронтой харьцуулахад хэр төвшинд явж байна вэ?**

-Манай улсын балетын урлаг 50-60 жилийн түүхтэй. Анх 1963 онд ДБЭТ байгуулагдсан цагаас эхэлж, сонгодог урлагийн талаарх ойлголт бий болсон. Өмнө нь Зөвлөлт холбоот улсад очиж мэргэжилтэн бэлтгэдэг байсан бол одоо дотооддоо суралцдаг боллоо. Жижиг, том гэлтгүй балетын сургуулиуд бий болж байна. Өөрөөр хэлбэл бид боловсон хүчингээ бэлтгэх бүрэн боломжтой боллоо шүү дээ. Тэр хэрээр манай бүжигчид дэлхийд өөрийн ур чадварыг таниулах, хүчээ үзэх боломж нээгдсэн. Манай бүжигчид дэлхийн том том балетын театруудад ажиллаж байна. Эндээс харахад манай улсын балетын ирээдүйд маш том боломж бий.

**-Монголын үндэсний балетын сургууль саяхан байгуулагдсан. Сургуулийнхаа талаар танилцуулахгүй юу. Та өөрөө багшилж байгаа юу?**

-Монголын үндэсний балетын сургууль байгуулагдаад гурван сар болсон. Одоо 2016-2017 оны элсэлтээ авч байгаа. Сургуулиа олон улсын балетын сургуулийн төвшинд хүргэхийн төлөө ажиллана. Би зургадугаар сард Монголд байна. Энэ хугацаандаа өөрөө багшилж, маш нарийн ажиллахаар төлөвлөсөн. Би байхгүй ч гэсэн манайд туршлагатай олон багш нар бий.

**-"Night of ballet"-ыг хүн бүр мэддэг боллоо. Энэхүү наадам хэр үр дүнтэй болж байна вэ?**

-Анх 2011 онд "Night of ballet"-ыг хийснээс хойш балетыг сонирхдог, хүүхдээ хичээллүүлэхийг хүсдэг эцэг эхчүүд олон болсон. Дугуйлангууд ч их болж. Үзэгчдийн тоо ч ихэссэн. Ингээд бодохоор багагүй үр дүн үзүүлсэн. Балет бол залуу хүний урлаг. Тийм учраас бид залуу насны дүрэлзсэн эрч хүчээр хийе, бүтээе гэсэн сэтгэлтэй явах ёстой. Тэгж байж балетын урлаг хөгжинө.

**-Монголд "Чакот" брэндийн дэлгүүр нээгдэнэ гэсэн. Яагаад энэ брэндийг оруулж ирэх болов?**

-Бидэнд мэргэжлийн хувцас үнэхээр чухал үүрэгтэй байдаг. Монголд мэргэжлийн хувцас зардаг дэлгүүр ч байдаггүй. Би Монголд ирэх болгондоо харамсдаг. "Цөмөөхэй" балетад тоглож байгаа хүүхдүүдийг хараад их өрөвддөг байлаа. Яг ямар хувцас өмсөх ёстойгоо хүүхдүүд нь ч, эцэг эхчүүд нь мэддэггүй. Би 10 гаруй жил "Чакот" компанитай ярилцсаны үр дүнд Монголд албан ёсны салбарыг нь нээж байна. Энэ дэлгүүр нээгдснээр балетын хүүхдүүд мэргэжлийн, чанартай хувцас хэрэглэх боломжтой болно. Энэ ч гэсэн балетын урлагт гарч байгаа нэг дэвшил.

МM-ИЙН ТОДРУУЛГА

# ЭНЭ САРЫН 4-НД ТРОЛЛЕЙБУС ҮЙЛЧИЛГЭЭНД ГАРАХГҮЙ

Н.ЗАЯА

*Энэ сарын 4-нд "Автомашингүй өдөр" болох гэж буйтай холбогдуулан өчигдөр Үндэсний мэдээллийн төвд албаны хүмүүс хэвлэлийн бага хурал хийлээ. Энэ үеэр ЗЦГ-ын УСХ-ийн дарга, хурандаа Э.Бөхбатаас Автомашингүй өдөртэй холбоотой зарим зүйлийг тодруулла а.*

**-"Автомашингүй өдөр" энэ бямба гарагт тохионо. Энэ өдөр Замын цагдаагийн газрынхан ямар зохион байгуулалттай ажиллах вэ?**

-Монгол Улсын Засгийн газрын Олон улсын спортын тэмцээн, наадам зохион байгуулах тухай 325 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд бүх нийтээр биеийн тамир, спортыг дэмжих зорилгоор жил бүрийн зургадугаар сарын эхний долоо хоногийн бямба гарагийг "Автомашингүй өдөр" болгон тэмдэглэдэг. Энэ өдөр "Улаанбаатар-Марафон" олон улсын гүйлтийн тэмцээнийг зохион байгуулдаг уламжлалтай. Энэ жилийн олон улсын гүйлт зургаадугаар сарын 2-ны өдөр тохионо. Автомашингүй өдөр болон марафонтой холбогдуулан ЗЦГ-аас 330 гаруй цагдаа уртасгасан цагаар гарч ажиллана.

**-Энэ үеэр зам хэсэгчлэн хаана гэсэн. Хэдэн чиглэлд зам хааж байгаа вэ. Иргэд хотын аль хэсгээр авто замын хөдөлгөөнд оролцох боломжтой вэ?**

-"Автомашингүй өдөр"-өөр олон улсын марафон гүйлтийн тэмцээн болно. Үүнтэй холбогдуулан автозамыг хэсэгчлэн хаана. Нийт найман чиглэлд зам хааж байгаа. Тодруулбал, Чингис хааны талбай, Их тойруугаас дотогш зам, Сөүлийн гудамж, Анкарагийн гудамж, Сүхбаатарын гудамж, Залуучуудын гудамж, Энхтайвны өргөн чөлөө буюу зүүн дөрвөн замаас баруун дөрвөн зам хүртэл, Чагдаржавын гудамж, Олимпийн гудамжнаас дотогш замуудыг хаахаар болсон. Өглөө 08:00 цагаас оройн 18:00 цаг хүртэл замын хөдөлгөөнийг хаана.

**-Авто зам хэсэгчлэн хаахтай холбогдуулан нийтийн үйлчилгээний чиглэлд өөрчлөлт орсон байх. Энэ талаар мэдээлэл өгөхгүй юу?**

-"Улаанбаатар марафон-2016" Олон улсын гүйлтийн тэмцээний үеэр зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд Бага тойруу, Энхтайвны өргөн чөлөөний Баруун 4 замын уулзвараас Зүүн 4 зам хүртэлх авто зам, Сөүлийн гудамж, Бээжингийн гудамж, Анкарагийн гудамж, Самбуугийн гудамжны автозамын хөдөлгөөнийг хязгаарлах тул эдгээр гудамж, замаар үйлчилгээ үзүүлдэг нийтийн тээврийн 31 чиглэлийн 311 тээврийн хэрэгслийн чиглэл, замналд өөрчлөлт орсон. Хотын төвийн буюу Их тойруу доторх гол гудамж, замууд хаагдах үед нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлүүд хойгуураа Их тойруугийн гудамж, урдуур Нарны зам, Намъянжугийн гудамжаар явах бөгөөд хойноос урагш болон урдаас хойш явдаг босоо чиглэлүүд Баруун 4 зам, Нарны гүүр, Зүүн 4 замаар үйлчилэхээр болсон. Энхтайваны өргөн чөлөөний авто замын тодорхой хэсгийн хөдөлгөөн хаагдах тул тухайн өдөр троллейбус үйлчилдэг Т:2 "5 шар - Ботаник", Т:4 " Ботаник-Вокзал", Т:5 "3,4 хороолол-Офицеруудын ордон" чиглэлүүд явахгүй болохыг иргэддээ анхааруулъя.

**-"Авто машингүй өдөр" гурав дахь жилдээ болж байгаа. Уг өдрийг тэмдэглэх нь ямар ач холбогдолтой вэ. Энэ жил ямар онцлогтой болж байна вэ?**

-Эрүүл мэнд, спортын яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, ГССҮТ, НЭМГ манайхтай хамтран зохион байгуулж байгаа. "Автомашингүй өдөр" нь автозамын ачааллыг үе шаттайгаар бууруулах, улмаар хүрээлэн буй орчин болоод нийгэмд автомашины хэрэглээнээс үүдэн учирч буй сөрөг нөлөөг багасгахад олон нийтийн анхаарлыг хандуулах зорилготой. Тиймээс автомашины хэрэглээнээс татгалзаж, нийтийн тээвэр, унадаг дугуй, явган зорчилт зэрэг автомашинаас бусад ачаалал багатай тээврийн хэрэгслийн хэрэглээг дэмжих, мөн замын хөдөлгөөний аюулгүй байдал, нийгэмд чиглэсэн мэдээлэл сурталчилгаа явуулах зэргээр жил бүр тэмдэглэн явуулдаг. Энэ жилийн хувьд "Зөвхөн өнөөдөр биш... Өдөр бүр" гэсэн уриан дор тэмдэглэж байгаа. Учир нь хүмүүс зөвхөн энэ өдөр л автомашин хэрэглэдэггүй. Маргаашаас нь эхлээд л машинаа унадаг. Энэ хандлагыг өөрчилж, өдөр тутам авто машинаас татгалзаж, байгаль дэлхийгээ хайрлая гэсэн санааг хүмүүст өгөхийг зорьж байна. Манай улсын хэмжээнд нийт 800 гаруй мянган тээврийн хэрэгсэл бий. Үүнээс 200 гаруй мянга нь 20 жилээс дээш наслалттай машинууд байдаг. 300 мянга нь 10 жилээс дээш наслалттай тээврийн хэрэгсэл. Энэ 10-20 жилийн наслалттай авто машин гэдэг аль хэдийн хэрэглээнээс гарсан гэсэн үг. Бид ийм л аюултай унааг унадаг. Одоо ГССҮТ-д ирж байгаа дуудлагын 14 хувь нь авто машины осол байдаг. Ихэнх хувийг 20-30 насны залуучууд эзэлдэг. Тэгэхээр авто машинаас татгалзах нь өөрийгөө болзошгүй аюулаас хамгаална. Мөн агаарын бохирдлыг бууруулахад чухал ач холбогдолтой.

# МЭДЭЭЛЭЛ

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016 оны 5 дугаар сарын 30
**Тендер шалгаруулалтын нэр:** "МИАТ" ТӨХК-ийн албан хэрэгцээнд Майкрософтын албан ёсны лицензтэй програм хангамж нийлүүлэх
**Тендер шалгаруулалтын дугаар:** 05/2016-Хд

МИАТ ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Майкрософтын албан ёсны лицензтэй дараах програм хангамж–ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
**Үүнд:**
1. Microsoft Windows 10 Pro – 250 ш
2. Office Standard 2016 (Word, Excel, PowerPoint, OneNote, Outlook, Publisher, Office Online) – 180 ш
3. Windows Server 2012 R2 Standard Server Licence – 10 ш
4. Windows Server Device Client Access License (CAL) – 250 ш
5. Microsoft SQL Server Enterprise Core 2 Software License – 2ш

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
**Үүнд:**
**Борлуулалтын хэмжээ:** 2013, 2014, 2015 оны аль нэг жилд 400,000,000 /Дөрвөн зуун сая/ төгрөгөөс багагүй
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 400,000,000 /Дөрвөн зуун сая/ төгрөгөөс багагүй
**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, тайлбар тодруулга, аудиторын дүгнэлтийн хамт 2013, 2014 он, 2015 он
**Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 3 жилийн аль нэг жилд 200,000,000 /Хоёр зуун сая/ төгрөгөөс багагүй ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн байна. /2013, 2014 он, 2015 он/
**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Microsoft Volume Licensing – Майкрософт корпорацийн том байгууллагын багц лицензжүүлэлт бүхий "Microsoft Products and Services Agreement" лицензийг нийлүүлэгч нь Майкрософт корпорацийн "Large Account Reseller/Licensing Solutions Provider" албан ёсны эрхтэй байх

*Тендерийн хамт 6,996,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.*

Тендерийг 2016 оны 6 дугаар сарын 15-ны 10:00 цаг–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 6 дугаар сарын 15-ны 10:30 цаг -т нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.**
**Дотоодын давуу эрх тооцохгүй.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**МИАТ ХК, ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 10-Р ХОРОО, БУЯНТ-УХАА ДАХЬ МИАТ ТӨХК-ИЙН ТӨВ БАЙР, ЗАХИРГАА, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС 213 ТООТ**
**ГЭРЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.ЖАДАМБА УТАС: 70049852, 99780000**

## AN INVITATION FOR BID

May 30th, 2016
**Name of the Project:** For supply of Microsoft software licenses
**IFB No:** 05/2016-Хд

MIAT Mongolian Airlines invites sealed bids from eligible bidders for supply of the following permanent Microsoft software licenses.
1. Microsoft Windows 10 Pro – 250 pcs
2. Office Standard 2016 (Word, Excel, PowerPoint, OneNote, Outlook, Publisher, Office Online) – 180 pcs
3. Windows Server 2012 R2 Standard Server Licence – 10 pcs
4. Windows Server Device Client Access License (CAL) – 250 pcs
5. Microsoft SQL Server Enterprise Core 2 Software License – 2 pcs

Submission of the document shall be in written form/or additional document/ and in order to participate in the bid, parties shall deposit a non-refundable fee of 50,000 /fifty thousand/MNT or in an equivalent amount in a free convertible currencies. The payment can be transferred to the Golomt Bank account number 1102036061 of the MIAT Mongolian Airlines (МИАТ ТӨХК). Bids shall be valid for 45 days from the date of its opening.

Bidders must meet the following financial and experience requirements. **Herein:**
**Sales volume**: Each of year 2013, 2014 and 2015, sales volume has to be no less than of 400,000,000 /four hundred million/ MNT.
**Hedge funds and available credit amount:** 400,000,000 /Four hundred million/ MNT.
Submission of audited financial statements of annual figures: The last 3 years with audited financial statements and explanatory notes have to be certified to the auditor /2013, 2014, 2015/
**The average cost of similar work undertaken over the last three years:** In any year in the last 3 years, has to have performed in the amount of no less than 200,000,000 /Two hundred million/ MNT in similar work in accordance with agreement. /2013, 2014 and 2015/
**Official license is required to submit:**
Microsoft Volume Licensing - Microsoft Products and Services Agreement license provider must be an official Microsoft Large Account Reseller/Licensing Solutions Provider (with license).

With the submission, include 6,996,000 /six million nine hundred and ninety six thousand/ MNT with the equivalent to the value of the tender guarantee.

Bidders must submit their documents prior to the date of 10:00 AM, June 15th, 2016 and opening will be held on 10:30 AM, June 15th, 2016 with the presence of the participants wishing to be involved.

**Foreign persons have the right to submit a bid.**
**Domestic privilege shall not be granted.**

*Interested parties can obtain the bidding documents and other information from the following address.*

**ADDRESS: ROOM NUMBER #213, MIAT BUILDING, BUYANT-UKHAA-10, KHAN-UUL DISTRICT, ULAANBAATAR, MONGOLIA.**
**PHONE: 70049852, 99780000**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016 оны 5 дугаар сарын 30
**Тендер шалгаруулалтын нэр:** "МИАТ" ТӨХК-ийн албан хэрэгцээнд Оракл корпорацийн програм хангамжийг лицензжүүлэх компанийг сонгон шалгаруулах
**Тендер шалгаруулалтын дугаар:** 13/2016-Н

МИАТ ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Оракл(Oracle) Корпорацийн програм хангамжийг лицензжүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. **Үүнд:**
1. Oracle Database Enterprise Edition 12c (Хугацаагүй/Perpetual) – 12 processor license
2. Software update license & support – 1 year
3. Oracle Advanced Compression 12c (Хугацаагүй/Perpetual) – 12 processor license

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**
**Борлуулалтын хэмжээ:** 2013, 2014, 2015 он тус бүрийн борлуулалтын хэмжээ 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөгөөс багагүй
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 1,000,000,000 /Нэг тэрбум/ төгрөгөөс багагүй
**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, тайлбар тодруулга, аудиторын дүгнэлтийн хамт 2013 он, 2014 он, 2015 он
**Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 3 жилийн аль нэг жилд 400,000,000 /Дөрвөн зуун сая/ төгрөгөөс багагүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна. /2013 он, 2014 он, 2015 он/
**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:**
1. Оракл (Oracle) корпорацийн Монгол дахь албан ёсны Gold Partner нийлүүлэгч гэдгийг нотолсон баримтыг ирүүлэх/гэрчилгээ/.
2. MAF /Manufacturing Authorization Form/ буюу Ораклаас тус тендерт оролцохыг зөвшөөрсөн зөвшөөрөл байх/ирүүлэх

*Тендерийн хамт 10,352,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.*

Тендерийг 2016 оны 6 дугаар сарын 30-ны 14:00 цаг–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 6 дугаар сарын 30-ны 14:30 цаг -т нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.**
**Дотоодын давуу эрх тооцохгүй.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**МИАТ ХК, ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 10-Р ХОРОО, БУЯНТ-УХАА ДАХЬ МИАТ ТӨХК-ИЙН ТӨВ БАЙР, ЗАХИРГАА, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС 213 ТООТ**
**ГЭРЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.ЖАДАМБА УТАС: 70049852, 99780000**

## AN INVITATION FOR BID

May 30th, 2016
**Name of the Project:** For supply of Oracle software licenses
**IFB No:** 13/2016-Н

MIAT Mongolian Airlines invites sealed bids from eligible bidders for supply of the following permanent Microsoft software licenses.
1. Oracle Database Enterprise Edition 12c (Perpetual) – 12 processor license
2. Software update license & support – 1 year
3.Oracle Advanced Compression 12c (Perpetual) – 12 processor license

Submission of the document shall be in written form/or additional document/ and in order to participate in the bid, parties shall deposit a non-refundable fee of 50,000 /fifty thousand/MNT or in an equivalent amount in a free convertible currencies. The payment can be transferred to the Golomt Bank account number 1102036061 of the MIAT Mongolian Airlines (МИАТ ТӨХК). Bids shall be valid for 45 days from the date of its opening.

Bidders must meet the following financial and experience requirements.
**Herein:**
**Sales volume:** Each of year 2013, 2014 and 2015, sales volume has to be no less than of 1,000,000,000 /One billion/ MNT.
**Hedge funds and available credit amount:** 1,000,000,000 /One billion/ MNT.
Submission of audited financial statements of annual figures: The last 3 years with audited financial statements and explanatory notes have to be certified to the auditor /2013, 2014, 2015/
**The average cost of similar work undertaken over the last three years:** In any year in the last 3 years, has to have performed in the amount of no less than 400,000,000 /Four hundred million/ MNT in similar work. /2013, 2014 and 2015/
**Official license is required to submit:**
1. Must be a licensed Gold Level Oracle Partner.
2. Must have MAF /Manufacturing Authorization Form/ upon Oracle's acceptance for Tender.

With the submission, include 10,352,000 /Ten million three hundred and fifty two thousand/ MNT with the equivalent to the value of the tender guarantee.

Bidders must submit their documents prior to the date of 14:00 PM, June 30th, 2016 and opening will be held on 14:30 PM, June 30th, 2016 with the presence of the participants wishing to be involved.

**Foreign persons have the right to submit a bid.**
**Domestic privilege shall not be granted.**

*Interested parties can obtain the bidding documents and other information from the following address.*

**ADDRESS: ROOM NUMBER #213, MIAT BUILDING, BUYANT-UKHAA-10, KHAN-UUL DISTRICT, ULAANBAATAR, MONGOLIA. PHONE: 70049852, 99780000**

# ДЭЛХИЙ

## ХЯТАД, БНАСАУ-ЫН ХАРИЛЦАА САЙЖИРЧ БАЙНА



Б.ДАВАА

Пхеньян өнгөрөгч сарын 31-ний өдрийн үүрээр Японы тэнгисийн зүг пуужин хөөргөсөн ч амжилтгүй болсон талаар БНСУ-ын цэргийн штабаас мэдээлсэн. Вонсаны ойролцоох бүс нутгаас Мусудан гэх дунд зайн баллистик пуужин туршсан байж магадгүй гэж албаныхан үзэж байсан юм. Тэгвэл энэ өдрөөс яг нэг хоногийн дараа буюу Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Хойд Солонгосын төр засгийн өндөр албан тушаалтан БНХАУ-д ажлын айлчлал хийлээ. Бусад улс орныг бодвол, Пхеньянтай ойрын харилцаатай гэгддэг Хятад улс ч НҮБ-ын тус улсын эсрэг авсан хориг арга хэмжээг дэмжиж буйгаа илэрхийлж, тус улсын эсрэг бодлого баримтлах болсон юм. Тэгвэл энэ өдөр БНАСАУ-ын Хөдөлмөрийн намын төв хорооны дэд дарга Ри Су Ён БНХАУ-д ажлын айлчлал хийж, тус улсын дарга Си Зиньпинтэй уулзжээ. Хойд Солонгос улсын өндөр дээд албан тушаалтны энэ удаагийн айлчлал хоёр орны хүйтэрсэн харилцаа эргэн сайжирч буйг харуулж байна хэмээн зарим эх сурвалж онцолж байна. Умард Солонгосын Гадаад хэргийн сайд асан Ри Су Ён саяхан Хөдөлмөрийн намын намын төв хорооны дэд даргаар тушаал дэвшсэн аж. Тэрбээр Хятадын даргатай уулзах үеэрээ өнгөрсөн сарын эхээр зохион байгуулагдсан Хөдөлмөрийн намын VII их хурлын тухай дурьдсанаас гадна Умард Солонгосын удирдагч Ким Чен Уны дамжуулсан үгийг уламжилсан байна. Синьхуа агентлагийн мэдээлснээр Умардын удирдагч Солонгосын хойг, Зүүн Хойд Азийн бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангахын тулд Хятадтай уламжлалт худалдааны харилцаагаа бэхжүүлж, хөгжүүлэхийн тулд хүчин чармайлт гарна гэдгээ илэрхийлжээ. Харин Си Зиньпин хоёр орны нөхөрсөг харилцаа, хамтын ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгдгөө мэдэгдсэн байна. Мөн сүүлийн үед улам бүр хурцдаж байгаа Солонгосын хойг дахь нөхцөл байдлын тухайд Хятад улсын байр суурь өөрчлөгдөхгүй гэдгийг Си дарга сануулсан байгаа юм. Хөдөлмөрийн намын төв хорооны дэд дарга Ри Су Ён ч гэсэн Ким Жон Уны хэлсэн үгийг дайж, цаашид ч тус улсын Засгийн газар цөмийн зэвсгийн хөгжүүлэлт баллистик пуужингийн туршилтаа үргэлжлүүлнэ гэдгээ илэрхийлсэн байна. Хөдөлмөрийн намын VII их хурлаар Хойд Солонгос цөмийн зэвсгийн хөгжүүлэлт, эдийн засгаа сэргээх гэсэн хоёр чиглэлийг баримтлахаар болсон ажээ. Уулзалтын үеэр энэ талаар Ри Су Ён Хятадын даргад уламжилсан байна. Харин талууд харилцаагаа сэргээхэд чиглэсэн чухам ямар алхмуудыг хийх нь тодорхойгүй байгаа юм. Гэхдээ БНСУ-ын төв хэвлэлийн өчигдрийн дугаарт Хойд Солонгосын албан тушаалтан Хятадын талаас нэг сая тонн хоол хүнсний бүтээгдэхүүний тусламж үзүүлэхийг хүссэн тухай мэдээлжээ. Харин Хятадын тал хэмжээг нь бууруулж, 500 тонн хүнсний бүтээгдэхүүний тусламж үзүүлэхээ илэрхийлсэн гэсэн мэдээлэл байгаа юм. Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн Хойд Солонгос улсын эсрэг авсан хориг арга хэмжээний зүйл заалтыг зөрчихгүй гэдгийг албаныхан тодотгож байна. Си дарга Умард Солонгосын дээгүүр албаны төлөөлөлтэй 2013 оны тавдугаар сараас хойш анх удаа уулзаж байгаа юм. Ямартай ч, Хятад, Умард Солонгосын харилцаа үл ялиг дулаарах байдал ажиглагдаж байна. Гэвч сүүлийн үед дахин пуужин туршсантай холбоотойгоор АНУ-ын Засгийн газар Хойд Солонгос эсрэг санхүүгийн хориг арга хэмжээгээ чангаруулж байгаагаа мэдэгдээд байна.

## Доналд Трамп Их Британид айлчилна

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль ирэх арваннэгдүгээр сард болох билээ. Тус сонгуульд Бүгд найрамдах намаас нэр дэвших нь нэгэнт тодорхой болоод буй үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп энэ сарын 24-ний өдөр Их Британид айлчлахаар болжээ. Европын холбооноос гарах эсэх талаархи бүх нийтийн санал асуулга болсны маргааш тус улсад айлчилна гэдгээрээ Трампын төлөвлөгөө олон нийтийн анхаарлын төвд байна. Олон нийтийн өмнө элдэв хачирхалтай мэдэгдэл хийж, зарим нэгнийх нь эгдүүцлийг төрүүлж харин нөгөө хэсгийнх нь дэмжлэгийг хүлээх Трамп Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөнө гэдгээ мэдэгдсэнээс хойш анх удаагаа тус улсад зочлох гэж байна. Тэрбээр Их Британид гольфийн талбай нээж буй бөгөөд нээлтийн ёслолыг нь далимдуулан очихоор болжээ. Түүнийг очихоос яг нэг хоногийн өмнө Их Британид Европын холбооноос гарах эсэх асуудлаар санал хураалт болно. Тус улсын Ерөнхий сайд Дэвид Камерон, АНУ-ын төрийн тэргүүн Барак Обама нар ЕХ-д Их Британи үлдэх хэрэгтэй гэж үздэг бол Доналд Трамп эсрэгээрээ гарах хэрэгтэй гэсэн байр суурийг илэрхийлж байгаа юм. Түүнчлэн, Трамп Америк руу мусульман шашинтнууд нэвтрэхийг хориглох ёстой гэж хэлснийх нь улмаас Англид ялгаварлан гадуурхалтын эсрэг кампанит ажил өрнөж, Д.Трампыг Британи руу нэвтрэхийг хориглохыг шаардсан гарын үзэг цуглуулах ажиллагаа болж, парламентаар хэлэлцэх хэмжээний асуудал дэгдсэн удаатай. Бизнесмэн эрийн Британид юу амжуулах нь тодорхойгүй ч, гольфийн талбайн нээлтэд оролцоно гэдэг нь л одоогоор тодорхой болоод байгаа юм. Гэхдээ айлчлалынхаа үеэр хэлэх үг нь олны анхаарлыг маш ихээр татаж байна.

## Сонгуулийн сурталчилгаа олонд таалагдсангүй



Энэ долоо хоногийн сүүлчээр Мексикт парламентын сонгууль болно. Тэгвэл Мексикийн Мехико хотноо нэгэн улс төрийн намын анхаарал татахуйц сурталчилгаа зохион байгуулагджээ. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагааг өнгөрсөн сарын 31-ний өдөр тус хотноо "Нью Аллиансе" гэх улс төрийн жижиг хүчин зохион байгуулжээ. Улмаар энэ үеэр цагаан малгай өмсч, цээжээ нүцгэлэн цагаан болон цэнхэр өнгийн будгаар намынхаа бэлгэ тэмдгийг зурсан дөрвөн эмэгтэй "Мехико хотын эмэгтэйчүүд, охидын төлөө" гэж бичсэн лоозонгийн өмнө инээмсэглэн намын дарга Луйс Кастрогийн хамт зогсч байжээ. Түүнчлэн, нуруу хэсэгтээ хөхний даруулгыг дуурайлган зурж, түүнийхээ дор "Биеэ чөлөөл" гэх үгийг бичсэн байсан аж. Мехико хот нь энэ жил албан ёсны нэр болох "Мексикийн холбооны тойрог " гэх нэрээ "Мехико хот" болгон өөрчилж 32 дахь муж гэсэн статустай болсон юм. Энэ дагуу хотын хууль тогтоох байгууллагыг бүрдүүлэхийн тулд орон нутгийн сонгуулийг энэ долоо хоногийн сүүлчээр явуулахаар болсон байдаг. Ямартай ч, дээрх улс төрийн жижиг хүчнийхний олныг татах гэсэн оролдлого бүтэлгүйтсэн сурагтай. Үйл ажиллагааны зураг олон нийтийн цахим сүлжээгээр цацагдаж, олны дургүйцлийг ихээр төрүүлээд байна. Твиттер хуудаснаа гэхэд л тус үйл ажиллагаатай холбоотой эсэргүүцсэн жиргээ хэдэн мянгаараа тоологдож буй аж.

## Согтууруулах ундаа хэрэглэх насны дээд хязгаарыг тогтоов



Ирэх оны арванхоёрдугаар сарын 1-нээс эхлэн зөвхөн 21-ээс дээш насны хүмүүс согтууруулах ундаа худалдаж авч, хэрэглэж болно гэж Малайзын Эрүүл мэндийн яам мэдэгдлээ. Тус улсын Эрүүл мэндийн сайд С.Субраманиамын хэлснээр "Малайзад бүтээгдэхүүнээ борлуулж буй үйлдвэрлэгчид согтууруулах ундааны эрүүл мэндэд учруулах хор уршигийн талаар бүтээгдэхүүний шошгон дээр заавал бичсэн байх ёстой" аж. Насанд хүрээгүй хүүхдүүд согтууруулах ундаа хэрэглэж байгаа болон согтууруулах ундаанаас үүдэлтэй хүчирхийллийг таслан зогсоохын тулд согтууруулах ундаа хэрэглэж болох насны доод хязгаар 18 байсныг 21 болгох гэж байгаа ажээ. Энэ арга хэмжээ нь согтууруулах ундааны хэрэглээг багасгахад чиглэсэн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын стратегийн бодлогын нэг хэсэг гэж сайд нэмж хэлсэн байна.

## Дэлхийн хамгийн урт нүхэн гарц Швейцарьт нээгдлээ

Альпийн нурууны бэлээр 57 километрийн урттай дэлхийн хамгийн урт нүхэн гарц энэ сарын 1-ний өдөр Швейцарьт нээлтээ хийжээ. Нээлтийн ёслолын ажиллагаанд Германы Канцлер Ангела Меркель, Францын Ерөнхийлөгч Франсуа Олланд, Италийн Ерөнхий сайд Маттео Рензи нарын хүндтэй зочид төлөөлөгчид оролцож, тус нүхэн гарцаар явах хамгийн анхны галт тэргэнд тухалсан байна. Хонгилийн бүтээн байгуулалтын ажил эхлэх хүртэл нийтдээ 17 жилийн хугацаа, 12 тэрбум ам.долларын хөрөнгө зарцуулагджээ. Хонгил ирэх арванхоёрдугаар сараас эхлэн ашиглалтад орж, түүгээр галт тэрэгнүүд дайран өнгөрч тээвэрлэлт хийх юм. Албан ёсоор хонгил ашиглалтад орсноор Швейцарийн Цюрих болон Италийн Милан хотын хооронд хийгдэх тээвэрлэлтийн хугацаа нэг цагаар багасч, хоёр цаг 40 минутын хугацаанд тээвэрлэлт хийгдэх боломжтой болж байгаа юм. Дэлхийн хамгийн урт нүхэн гарц гэсэн амжилтыг өмнө нь Японы Сейкан туннел эзэмшиж байсан юм. Тус хонгилын урт нь 53.9 км урт. Тэгвэл Швейцарьт нээлтээ хийсэн уг хонгил түүнээс даруй дөрвөн км-ээр урт тул ийнхүү дэлхийн хамгийн урт туннель болж байна. Харин гуравдугаарт 50.5 км-ын урт Их Британи, Францыг холбох туннел нэрлэгдэж байгаа юм.



# ЗАВСАРЛАГА

УРЛАН



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +25
Шөнө 9

Нөгөөдөр
Өдөр +15
Шөнө +6

## Өдрийн зурхай

**Аргын тооллын:** *2016 оны 6-р сарын 3, Баасан гараг*

**Билгийн тооллын:** *Шинийн 28. 7 улаан мэнгэтэй Хөхөгчин туулай өдөр*

**Наран ургах/шингэх:** *06:08 / 21:39*

**Үс засуулбал:** *Өлзийтэй сайн.*



Тухайн өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн баүхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнэс эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, гарагийг тахих, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиаболой. Хол газар явaaр одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

СОНИРХУУЛАХАД

## Тайлор Свифт дахиад л ганц бие боллоо

Б.ДАВАА

Дуучин Тайлор Свифт , DJ Калвин Харрис нар хоёр тийш болжээ. Өнгөрсөн жилийн гуравдугаар сард тэд болзож эхэлсэн бөгөөд олны анхаарлын төвд байх хосуудын нэг болж байсан юм. Улмаар өнгөрөгч гуравдугаар сарын 6-нд нэг жилийн ойгоо нүсэр тэмдэглэж байсан удаатай. Тэднийг харсан зарим гэрчүүд тун удахгүй хуримын зар дуулгах нь хэмээн таамаглаж байв. Тэгвэл хосууд нэг жилийн ойгоо тэмдэглээд удсан ч үгүй салж буйгаа дуулгалаа. Сүүлийн үед Калвин тун ч азгүй байгаа. Өнгөрсөн сарын 20-нд авто осолд орж, эмнэлэгт хэвтэж, дөрвөн тоглолтоо цуцалсан юм. Харин Тайлор Свифт дахиад л ганц бие болов. Дуучин бүсгүйн хувьд өмнө нь Жое Жонас, Жон Майэр, Харри Стайл, Тайлор Лотнер, Жэйк Жилленхол зэрэг олны танил залуустай дотно харилцаа үүсгэж байсан ч, харилцаа нь удаан үргэлжлээгүй гэдэг.











*Хөлбөмбөгийн талбайг гурван удаа тойрсонтой тэнцэх гайхалтай урт усан гулгуур "Скай Ресорт"-д нээлтээ хийсэн билээ. City Slide нь дэлхийн олон оронд зохион байгуулагддаг бөгөөд Монголд анх удаа энэ зун болж байна. Энэ зуныг сайхан дурсамжтай өнгөрөөхийг хүсвэл City Slide-д заавал очоорой.*

*6 сарын 1-5 өдрүүдэд болох шоуны тасалбар худалдаанд гарч эхэлсэн тул http://www.cityslide.mn/index.php -ээс тасалбараа захиалаарай.*